



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД  
ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛСЭН  
БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН  
ШИНЖИЛГЭЭ**

2024 он



**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХҮРЭХ ҮР  
ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛД  
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар хот  
2024 он

ННА 65  
ДАА 327  
А-751

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ  
ҮНЭЛСЭН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

“АрБиДи Консалтинг” ХХК-ийн судалгааны баг

Тус тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-76113207  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

ISBN: 978-9919-9136-9-4

## АГУУЛГА

Товчилсон үгс.....	5
Зургийн жагсаалт.....	6
Хүснэгтийн жагсаалт.....	8
Өмнөх үг.....	11
Хураангуй.....	13
1. Удиртгал.....	17
2. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналын өнөөгийн байдал.....	19
3. БШУС-ын 2022-2023 оны хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн бодлогын баримт бичгүүдэд дурдагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдалд хийсэн дүн шинжилгээ.....	22
Сургуулийн өмнөх боловсрол.....	22
Ерөнхий боловсрол.....	26
Мэргэжлийн боловсрол, сургалт.....	36
Дээд боловсрол.....	39
Насан туршийн боловсрол.....	41
Сургалтын биет орчин.....	43
Тусгай хэрэгцээт боловсрол.....	45
Шинжлэх ухаан, технологи.....	48
Бүлгийн дүгнэлт.....	50
4. БШУЯ-ны 2022-2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ.....	52

2022-2023 оны сайдын багцын төсвийн хуваарилалт, гүйцэтгэл ба хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт.....	52
Хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ба төсвийн зарцуулалт.....	57
Сургуулийн өмнөх боловсрол .....	57
Ерөнхий боловсрол .....	61
Бага боловсрол .....	61
Дунд боловсрол.....	62
Суурь боловсрол.....	64
Бүрэн дунд боловсрол.....	66
Мэргэжлийн боловсрол, сургалт.....	69
Дээд боловсрол.....	73
Насан туршийн боловсрол .....	76
Сургалтын биет орчин.....	79
Тусгай хэрэгцээт боловсрол .....	81
Шинжлэх ухаан, технологи .....	83
Хөтөлбөр, зориулалтын төсвийн гүйцэтгэл ба холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	87
Дээд боловсрол.....	87
Бүлгийн дүгнэлт .....	88
5. БШУЯ-ны 2022-2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох бусад байгууллага үнэлж дүгнэсэн байдал .....	90
Сургуулийн өмнөх боловсрол.....	91
Ерөнхий боловсрол .....	91
Сургалтын биет орчин.....	93
Мэргэжлийн боловсрол.....	94
Дээд боловсрол.....	95
Насан туршийн боловсрол .....	95
Бүлгийн дүгнэлт .....	98
Дүгнэлт, зөвлөмж .....	100
Дүгнэлт .....	100
Зөвлөмж .....	103
Ном зүй .....	105
Хавсралтууд .....	107

## ТОВЧИЛСОН ҮГС

<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>ДБ</b>	Дээд боловсрол
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ЕБ</b>	Ерөнхий боловсрол
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЗГСУМС</b>	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
<b>МБ</b>	Мэргэжлийн боловсрол
<b>МБС</b>	Мэргэжлийн боловсрол, сургалт
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
<b>ННФ</b>	Нээлттэй нийгэм форум
<b>СЯ</b>	Сангийн яам
<b>СӨБ</b>	Сургуулийн өмнөх боловсрол
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилго
<b>ХНХЯ</b>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>ХШҮ</b>	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
<b>ЮНЕСКО</b>	UNESCO буюу НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2022 он.....	53
Зураг 2.	Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2023 он.....	54
Зураг 3.	Төсвийн хуваарилалт ба хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт, өөрчлөлтөөр, 2022-2023 он.....	56
Зураг 4.	“Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	58
Зураг 5.	“Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2022-2024 он.....	59
Зураг 6.	“Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	60
Зураг 7.	Бага боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022 он .....	62
Зураг 8.	Дунд боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он.....	63
Зураг 9.	“Дунд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2022-2024 он.....	63
Зураг 10.	Суурь боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	64
Зураг 11.	“Суурь боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он .....	65
Зураг 12.	Бүрэн дунд боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	66
Зураг 13.	“Бүрэн дунд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он .....	67

Зураг 14.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	68
Зураг 15.	“Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он .....	70
Зураг 16.	“Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2022-2024 он .....	71
Зураг 17.	“Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл .....	72
Зураг 18.	“Дээд боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	73
Зураг 19.	“Дээд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он .....	74
Зураг 20.	“Дээд боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл .....	75
Зураг 21.	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	77
Зураг 22.	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он .....	77
Зураг 23.	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	78
Зураг 24.	Сургалтын биет орчны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он .....	80
Зураг 25.	Сургалтын биет орчны хөтөлбөрийн 2022 оны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	80
Зураг 26.	“Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	82
Зураг 27.	“Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	83
Зураг 28.	“Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он .....	84
Зураг 29.	“Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он .....	84
Зураг 30.	“Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт .....	86



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	“Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	22
Хүснэгт 2.	“Алсын хараа-2050”-ын хүний хөгжил бүлгийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт .....	24
Хүснэгт 3.	ТХЗ-4 ба БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцэл.....	25
Хүснэгт 4.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	27
Хүснэгт 5.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн тогтвортой байдал .....	28
Хүснэгт 6.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн “Алсын хараа-2050” бодлогын үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал .....	29
Хүснэгт 7.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал .....	30
Хүснэгт 8.	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д тусгагдсан боловч ТЕЗ-ийн “Ерөнхий боловсрол” хөтөлбөрт тусгагдаагүй хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд.....	31
Хүснэгт 9.	“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн ТХЗ-4-т тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт .....	32
Хүснэгт 10.	ТХЗ-4-ийн үр дүнгийн үзүүлэлтүүдээс ТЕЗ-ийн “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнд тусгагдаагүй үзүүлэлтүүд.....	34

Хүснэгт 11.	“Мэргэжлийн боловсрол, сургалт” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	36
Хүснэгт 12.	ТХЗ-4, БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцэл.....	38
Хүснэгт 13.	“Дээд боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	39
Хүснэгт 14.	ТХЗ-4-ийн үр дүнгийн үзүүлэлтээс БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдаагүй үзүүлэлтүүд.....	40
Хүснэгт 15.	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	41
Хүснэгт 16.	“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал.....	42
Хүснэгт 17.	“Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	43
Хүснэгт 18.	“Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал.....	44
Хүснэгт 19.	“Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал.....	46
Хүснэгт 20.	“Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он.....	48
Хүснэгт 21.	“Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал.....	49
Хүснэгт 22.	Төсвийн хуваарилалт ба хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт, 2022-2023 он.....	55
Хүснэгт 23.	Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он.....	91
Хүснэгт 24.	“Сургалтын биет орчин” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он.....	93
Хүснэгт 25.	“Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он.....	94

Хүснэгт 26.	“Дээд боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он.....	95
Хүснэгт 27.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Сургуулийн өмнөх боловсролын түвшин, 2021-2024 он.....	107
Хүснэгт 28.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Ерөнхий боловсролын түвшин, 2021-2024 он .....	108
Хүснэгт 29.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Мэргэжлийн боловсрол, сургалтын түвшин, 2021-2024 он....	113
Хүснэгт 30.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Дээд боловсролын түвшин, 2021-2024 он.....	114
Хүснэгт 31.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Насан туршийн боловсрол”, 2021-2024 он.....	115
Хүснэгт 32.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Сургалтын биет орчин” хөтөлбөр, 2022, 2024 он .....	116
Хүснэгт 33.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Тусгай хэрэгцээт боловсрол”, 2021-2024 он .....	117
Хүснэгт 34.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Шинжлэх ухаан, технологи”, 2021-2024 он.....	118
Хүснэгт 35.	Хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2022 он .....	119
Хүснэгт 36.	Хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2023 он .....	120

## ӨМНӨХ ҮГ

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийг Улсын Их Хурлаас батлахдаа ирэх онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг мөн баталдаг. Гэсэн хэдий ч жилийн төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийг Улсын Их Хурал хэлэлцэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнд анхаарал төдийлөн хандуулахгүй байгаа нь төсвийн хэлэлцүүлгүүдийн явцаас ажиглагдаж байна.

Иймд Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургуулийн өмнөх боловсрол”, “Ерөнхий боловсрол”, “Мэргэжлийн боловсрол, сургалт”, “Дээд боловсрол”, “Насан туршийн боловсрол”, “Тусгай хэрэгцээт боловсрол”, “Шинжлэх ухаан, технологи” зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлсон болон тэдгээрийн биелэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайланд үнэлсэн байдалд Нээлттэй нийгэм форумын захиалгаар “АрБиДи Консалтинг” ХХК-ийн судалгааны баг дүн шинжилгээ хийж, салбарын сайдын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлох, үр дүнгийн гүйцэтгэл, тайлагналыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг санал болгосныг сонирхогч талуудад хүргэж байна.

Судалгаагаар улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зарим зорилт Боловсрол, шинжлэх ухааны сайдын жилийн төлөвлөлтөд тусгалаа олохгүй байгаа, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй зэрэг анхаарах асуудлууд байгаа нь харагджээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын хөтөлбөрүүдэд дэвшүүлсэн жилийн зорилтууд, тэдгээрийн улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдтэй нийцлийг сайжруулах талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Судалгааг хийж гүйцэтгэсэн судалгааны баг, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч Д.Амаржаргал, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

*Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал*

## ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн хуулийн нэгдүгээр хавсралтад тусгагдсан Боловсрол, шинжлэх ухааны сайд (БШУС)-ын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн тогтвортой байдал, Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдалд үнэлэлт дүгнэлт өгч, Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрийг үнэлсэн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, холбогдох санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо. Тухайн жилүүдийн гүйцэтгэлийн үнэлгээг судлагдсан хугацааны өмнөх жил буюу 2021, дараах жил буюу 2024 онтой харьцуулах замаар дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн бид судлагдаж буй онуудад БШУЯ-ны зүгээс гүйцэтгэлийн тайландаа хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийг хэрхэн дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, бусад судалгаануудын үр дүнтэй харьцууллаа.

Өмнө нь хийгдсэн судалгаануудад төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-дын төсвийн гүйцэтгэлийн тайлан хангалттай бус, арга хэмжээ тус бүрээр хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг харуулдаггүйгээс төсөв, хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн хамаарлыг ялган харж, төсвийн үр ашгийг хэмжих боломжгүй байна гэсэн үр дүн гарсан. Мөн суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн үр дүн хоорондоо уялдахгүй байгаа талаар дурдсан байдаг.

Бидний хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ихэнхдээ тогтвортой биш байна. Түүнчлэн томьёолол нь өөрчлөгдөх тохиолдлууд байсан. Жишээлбэл, “5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь” гэсэн үзүүлэлт “сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь” гэсэн үзүүлэлттэй агуулгын хувьд ижил ч өөр үзүүлэлт мэтээр томьёологджээ. 2021 онтой харьцуулахад 2022, 2023 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлтээр гарцын буюу үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүдийг тодорхойлсон нь тун сайшаалтай хэрэг юм. Энэ нь сүүлийн үед төсөв, бодлогын уялдааг сайжруулж, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг дэмжиж байгаатай холбоотой гэж үзэж байна. Хэдий тийм ч ТХЗ-4, “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” зэрэг бусад бодлогын баримт бичигт тусгагдсан бүлэг дүүргэлт, хөдөлмөр эрхлэлт, жендэр, эрх тэгш байдлыг илэрхийлсэн чухал хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд тусгалаа олоогүй байгаад анхаарч, улсын төсвийн хөрөнгийг зарцуулснаар хүрэх үр дүнг эрх тэгш байдлыг хангасан, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимтай нийцүүлэн илүү оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Төсвийн гүйцэтгэлийг хэдийгээр хөтөлбөрөөр тайлагнасан боловч арга хэмжээ тус бүрээр гарахгүй тул хөтөлбөрийн зарим хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар дүн шинжилгээ хийх боломжгүй байв. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн суурь түвшнийг тодорхойлоогүй байснаас гадна жил жилийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо зохих суурь түвшин, тухайн үзүүлэлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл, чиг хандлага зэргийг төдийлөн ашигладаггүй нийтлэг дутагдал байна. Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тус бүр 1-2 удаа өөрчлөлт оруулж, төсвийг тодотгон ТЕЗ нарын төсвийн хуваарилалт өөрчлөгдсөн байтал хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүдэд ямар ч өөрчлөлт ороогүй. “Мэргэжлийн боловсрол” зэрэг хөтөлбөрийн зорилтот түвшнийг хүрсэн үр дүнд харьцуулахад

хэт өндөр хувиар давуулан биелүүлсэн байгаа нь анх төлөвлөхдөө жилийн дунджаас доогуур буюу хүчин чармайлт гаргахгүйгээр хялбар биелэгдэх зорилтот түвшнийг сонгосон байж болзошгүй байна. Тухайн хөтөлбөр, арга хэмжээнд төсөвлөсөн төсөв, түүний гүйцэтгэл холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, биелэлттэй төдийлөн хамааралгүй байх хандлага ажиглагдлаа. Мөн зарим хүрэх үр дүнгийн биелэлтийг БШУЯ өөрийн тайлагнасан, бусад байгууллагатай хамтран гаргасан тайланд тайлагнасан нь зөрүүтэй байгаагаас харахад хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь түвшин болон хүрэх түвшнийг оновчтой тодорхойлох, гүйцэтгэлийг бодитой тайлагнахад анхаарах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд суурилсан дээрх дүгнэлтүүдэд тулгуурлан судлаачдын зүгээс холбогдох байгууллагуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

#### *Хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлох чиглэлээр*

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг аль болох оновчтой байдлаар буюу тухайн салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийг илэрхийлэх, үр дүнгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бусад баримт бичгүүд болон ТХЗ зэрэг олон улсын жишигтэй нийцтэй байхаар тодорхойлох;
- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо жендэр, нийгмийн бүлэг зэргээр ангилсан зорилтот түвшнийг тодорхойлж, эрх тэгш байдал, хэнийг ч орхигдуулахгүй зарчмыг баримтлах;
- ТЕЗ-ийн хүрэх үр дүнгүүдийн үзүүлэлтүүдийг зөвхөн боловсролын хүртээмж биш чанартай боловсрол олгох чиглэлээр тодорхойлох;
- Хүрэх үр дүнгийн суурь түвшин, зорилтот түвшин, биелэлт зэргийг аль болох бодитой, боломжит тоон мэдээлэлд үндэслэж, бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн холбогдох түвшинтэй уялдуулан тодорхойлж, тооцох;



- Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг аль болох тогтвортой байлгаж, өөр хугацаанд харьцуулж дүгнэх боломжоор хангах;
- Төсөвт хэд хэдэн удаа тодотгол хийсэн байтал үр дүнгийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт ороогүй, ТЕЗ нар төсвийн саналаа хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хамт Сангийн яаманд хүргүүлсэн хувилбарт тусгагдсан төсөв өөрчлөгдсөн атал үр дүнгийн үзүүлэлтийн санал өөрчлөлт оролгүй батлагдах тохиолдол түгээмэл байгаад анхаарч, цаашид төсөвт тодотгол хийх, эсхүл төсвийн саналд өөрчлөлт орох тохиолдолд үр дүнгийн үзүүлэлтүүдэд холбогдох бодит өөрчлөлтийг тусгадаг байх.

#### *Хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, тайлагналын чиглэлээр*

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, учир шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг тайлбарладаг байх;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой мэдээллийг олон нийтэд илүү нээлттэй болгож, салбарын байгууллагууд, мэргэжлийн хүмүүстэй нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар дараа жилийн төсвийн төлөвлөлтийг бодитой, үр дүнд чиглэсэн, бодлогын зорилготой уялдаатай болгох;
- Цаашид 5 настай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж зэрэг суралцагчдын суралцах чадварын үзүүлэлтүүд, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт гэх зэрэг гүйцэтгэлийг нь сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдэд илүүтэй анхаарал хандуулж, төсвөө оновчтой хуваарилах тал дээр анхаарах.

## 1. УДИРТГАЛ

Төсвийн тухай хуулийн 14.3 болон 41.2.3-т заасны дагуу ТЕЗ өөрийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг тайлагнах үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу БШУЯ өөрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлдэг. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийн талаар тусгахаас гадна мөн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийг тайлагнах үүрэгтэй байдаг юм. Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-өөс 2022 онд хийсэн “Төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайлагналын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ”-нд дурдсанаар Засгийн газрын зүгээс нэгтгэсэн хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг ТЕЗ-аар тайлагнасан боловч хөтөлбөр, арга хэмжээнд хамаарах төсөв, гүйцэтгэлийн дүнг арга хэмжээ тус бүрээр иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнээгүй, хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар дүн шинжилгээг хийгээгүй байна гэж дүгнэсэн байдаг. Өөрөөр хэлбэл тухайн оны төсвийн хуулийн Хавсралт 1-д тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд болон батлагдсан төсвийн хоорондын хамаарлыг дүгнэх боломж бүрэн бүрдээгүй байна.

БШУЯ нь НҮБХХ-тэй хамтран төсвөө үр дүнд суурилсан байдлаар төсөвлөх ажлууд хийгдэж байгаа бөгөөд “ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-аас гадна БШУЯ төсвийн төслөө үр дүнд суурилсан байдлаар сүүлийн 2 жил бэлтгэжээ.

Өөрөөр хэлбэл тус яам төсвийн төлөвлөлтийн явцдаа өөрийн төсвийн хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хөгжлийн бодлого, ТХЗ зэрэгтэй нийцүүлэн тодорхойлж, төсвийг төлөвлөхөөс гадна гүйцэтгэлийн тайланг мөн боловсруулж байна. Тухайлбал, НҮБХХ-тэй хамтран БШУЯ 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдэд үнэлгээ хийсэн юм.

Цаашид төсвийн гүйцэтгэлийн тайланг илүү боловсронгуй болгох, төсөв, хүрэх үр дүнгийн хоорондын хамаарлыг илүү тодорхой болгох замаар төсвийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс сонгогдсон яам болох БШУЯ-ны 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрийг үнэлсэн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон холбогдох санал, зөвлөмж боловсруулахыг энэхүү судалгааны ажлын хүрээнд зорилоо.

Судалгааны хоёрдугаар бүлэгт судалж буй асуудлын өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчны талаар авч үзсэн бол гуравдугаар бүлэгт Монгол Улсын төсвийн 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг 2021 он, 2024 оны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, ТХЗ болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан үр дүнгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан хэр тогтвортой, нийцтэй байгаад дүн шинжилгээ хийсэн. Судалгааны ажлын дөрөвдүгээр бүлэгт, БШУЯ-ны 2022-2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийлээ. Эцэст нь эдгээр үнэлгээг бусад холбогдох байгууллагуудын зүгээс хийсэн дүн шинжилгээ, судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгүүдтэй харьцуулж дүгнэв. Энэхүү судалгааны хүрээнд хийгдсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулснаа судалгааны ажлын сүүлийн бүлэгт орууллаа.

Тус судалгааны ажлыг гүйцэтгэх боломж олгосон Нээлттэй нийгэм форум (ННФ)-ын хамт олонд гүн талархал илэрхийлье.

*“АрБиДи Консалтинг” ХХК-ийн судалгааны баг*

## **2. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАГНАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Төсвийн тухай хуульд зааснаар ТЕЗ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэгтэй. Төсвийн гүйцэтгэлийг тайлагнахтай холбогдсон харилцааг тус хуулийн 14.3, 41.2.3, 41.2.7, 41.7 болон 54.5-д заасны дагуу зохицуулдаг.

ТЕЗ төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, тайланг улирал, жилээр гаргах ба жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны дотор Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийлгэсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр Төсвийн тухай хуульд заажээ.

Төсвийн тухай хуулиар мөн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг тусгайлан тодорхойлсон. Ихэнх ТЕЗ-дын төсвийн гүйцэтгэлийн тайланг үзэхэд төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний зөрүүг харуулсан байдлаар тайлагнах нь нийтлэг бөгөөд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнгийн биелэлтийн талаар мэдээлэл хангалтгүй байдаг. Тиймээс “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнг тайлагнах заавар”-ыг Сангийн сайдын 2023 оны 225 тоот тушаалаар баталсан юм. Үүний дагуу 2024 оноос эхлэн (2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг мөн адил) ТЕЗ төсвийн гүйцэтгэлийн тайланд хүрэх үр дүнгийн биелэлтээ тайлагнахаар болжээ. Энэхүү

зааврыг боловсруулахдаа БШУЯ болон ХНХЯ-ны холбогдох төсвийн гүйцэтгэлийн тайланг загвар болгосон. Тухайлбал, БШУЯ 2022, 2023 оны үр дүнгийн гүйцэтгэлийн тайлангаа энэхүү зааварт тусгагдсан зарчмыг баримтлан боловсруулсан байна.

НҮБХХ-ийн “ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслөөс 2022 онд “Төсвийн гүйцэтгэлийн болон үр дүнгийн тайлагналын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ”-г хийж, төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой цөөнгүй асуудлуудыг хөндөж тавьсан байдаг. Тухайлбал,

- Нэгтгэсэн хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг ТЕЗ-аар тайлагнасан боловч хөтөлбөр, арга хэмжээнд хамаарах төсөв, гүйцэтгэлийн дүнг арга хэмжээ тус бүрээр иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнээгүй, хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар дүн шинжилгээг хийгээгүй байсан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн”-гийн хэсэгт суурь түвшнийг тодорхойлоогүй, зорилтот түвшнийг тодорхойлохдоо суурь түвшнийг ашиглаагүй;
- ТЕЗ-ийн зарим хөтөлбөрийн зорилтот түвшнийг хүрсэн үр дүнд харьцуулахад хэт өндөр хувиар давуулан биелүүлсэн байгаа нь анх төлөвлөхдөө жилийн дунджаас доогуур буюу хүчин чармайлт гаргахгүйгээр хялбар биелэгдэх зорилтот түвшнийг сонгосон байж болзошгүй;
- Тухайн хөтөлбөр, зориулалтаар батлагдсан төсөв бүрэн зарцуулагдсан боловч зорилтот түвшинд хүрээгүй шалтгааныг тайлбарлаагүй эсхүл төсөв бүрэн зарцуулагдаж, үр дүнгийн үзүүлэлтүүд нь давж биелсэнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тайлбарлаагүй;
- ТЕЗ-ийн тухайн онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний

хүрэх үр дүнгийн тайлан хангалтгүй гэх зэрэг дүгнэлтүүдийг тайланд дурджээ.

Мөн дээр дурдсан НҮБХХ-ийн төслийн зүгээс БШУЯ-тай хамтран 2023 онд “Боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайлан”-г гаргасан байдаг. Тус тайланд БШУЯ-ны хэрэгжүүлдэг төсвийн боловсролын салбартай холбоотой 9 хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээг авч үзсэн (шинжлэх ухаан, технологийн хөтөлбөрийг авч үзээгүй гэсэн үг). Ингэхэд сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын 2022 оны үр дүнгийн үзүүлэлтийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 113.7 хувь гарсан бол ерөнхий боловсрол (ЕБ)-ын үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 94.4 хувь, “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 91.6 хувь, “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 98.1 хувь, “Дээд боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшний ерөнхий биелэлт 108.3 хувь гэж гарсан байна.

### 3. БШУС-ЫН 2022-2023 ОНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТЭДГЭЭРИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ДУРДАГДСАН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДТЭЙ НИЙЦТЭЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

#### Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын түвшинд 2022 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2 байсан бол 2023 онд “5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж гүйцэтгэлийн хувь” гэх чухал үзүүлэлтийг нэмснээр 3 үзүүлэлттэй болсон юм. Уг үзүүлэлтийг нэмсэн нь тун сайшаалтай хэрэг бөгөөд учир нь СӨБ-ын үндсэн зорилгуудын нэг нь бага насны хүүхдийг сургуульд бэлтгэх явдал юм.

*Хүснэгт 1. “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь	74	88.5
5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь	-	96.7
5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж гүйцэтгэлийн хувь	-	65
Сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь	86	-

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

2021 онд СӨБ-ын түвшинд хүрэх үр дүнгийн үзүүлэлт 6 байсны 5 нь хүрэх үр дүн гэхээс илүү нөөцтэй холбоотой буюу цэцэрлэгийн тоо, хамрагдах хүүхдийн тоо зэргийг авч үзжээ. Үнэн хэрэгтээ хамран сургалтын хувь гэх үзүүлэлтээр дээрх бүх үзүүлэлтийг илэрхийлэх боломжтой тул 2021 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй гэж дүгнэж болохоор байгаа юм. Харин 2022, 2023 онд эдгээр үзүүлэлтүүд гарц буюу үр дүнд суурилсан шинжтэй болсон нь сайшаалтай байна.

Дээрх хүснэгтээс үзэхэд “СӨБ-ын хамран сургалтын хувь” гэх нэг л үзүүлэлт хоёр жил дараалан тогтвортой ашиглагдсан бол 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтыг 2022, 2023 онд ялгаатай томьёолсон байна. Хоёр жил дараалан ашиглагдаж буй энэ үзүүлэлт нь насны бүлэг, хүйс, газар зүйн байршил, өрхийн нийгэм-эдийн засгийн байдлаар задрах боломжтой үзүүлэлт байгаа тул зорилтот түвшнийг ялгаатай тогтоох боломжтой. Түүнчлэн хамран сургалтын бохир жин үү, цэвэр жин үү гэдэг нь тодорхойгүй байгаа юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг авч үзэхэд СӨБ-той холбоотой дараах 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлт байна:

- СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин,
- Бүлэг дүүргэлт.

Харамсалтай нь уг 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2022-2023 онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд багтаагүй. Тиймээс дээрх 2 үзүүлэлтийг ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд оруулж, жил бүр хүрсэн түвшнийг нь хянаж байх хэрэгтэй юм.



## Хүснэгт 2. “Алсын хараа-2050”-ын хүний хөгжил бүлгийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2019 он (суурь түвшин)	2025 он (зорилтот түвшин)
СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин	81.5	89.4
Бүлэг дүүргэлт	33	25-30

*Эх сурвалж: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин*

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн ХШҮ-ний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд СӨБ-ын хувьд дараах 4 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг авч үзжээ. Үүнд:

- СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин;
- 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт;
- Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо;
- Бүлэг дүүргэлт.

Гэвч эдгээрийн зөвхөн 1 нь буюу “5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт” гэх үзүүлэлт ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй нийцтэй байна. Цэцэрлэгийн хүртээмж, бүлэг дүүргэлтийн асуудал хөндөгдсөөр байгаа өнөө цагт бүлэг дүүргэлт гэсэн үзүүлэлтийг зайлшгүй ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт болгон оруулах шаардлагатай байгаа юм.

2021 онд батлагдсан “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” баримт бичигт СӨБ-ын түвшинд чанар, хүртээмж, удирдлага, зохион байгуулалт гэсэн 3 чиглэлийн хүрээнд 8 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг авч үзсэн байдаг. Тэдгээрээс “бага сургуульд бэлтгэгдсэн 5 настай хүүхдийн эзлэх жин”, “СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин”, “5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт” гэсэн 3 үзүүлэлт тодорхой хэмжээгээр ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд тусгалаа олсон байгаа бол “цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо”, “бага орлоготой өрхийн хүүхдийн хамран сургалтын бохир жин”, “тусгай хэрэгцээт

хүүхдүүдийн хамран сургалтын бохир жин” зэрэг хүртээмж, эрх тэгш байдлыг илэрхийлсэн үзүүлэлтүүд байхгүй байна.

Дараах хүснэгтээр СӨБ-той шууд холбоотой ТХЗ-4 (чанартай боловсролыг дэмжих)-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрээс ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдэд тусгагдсан байдлыг харуулав.

*Хүснэгт 3. ТХЗ-4 ба БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцэл*

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд туссан эсэх	Тайлбар
2.4.1 Эрүүл мэнд, суралцахуй, сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд хэвийн 24-59 сартай хүүхдийн тус насны нийт хүүхдэд эзлэх хувь	Тодорхой хэмжээнд тусгагдсан	“5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж гүйцэтгэлийн хувь” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй тодорхой хэмжээнд хамааралтай байж болно.
4.2.2 Бага сургуульд орохоос нэг жилийн өмнөх СӨБ-д хамрагдалтын хувь	Бүрэн тусгагдсан	
4.2.3 Эерэг, урам зориг өгсөн гэрийн орчинд суралцаж буй 5 хүртэл насны хүүхдийн тус насны нийт хүүхдэд эзлэх хувь	Тодорхой хэмжээнд тусгагдсан	Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоог тооцдог тул “СӨБ-ын хамран сургалтын хувь” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тодорхой хэмжээнд тусгагдсан.
4.2.4 СӨБ-ын цэвэр хамран сургалтын хувь	Тодорхой хэмжээнд тусгагдсан	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт бохир, цэвэр жин гэдгийг тодорхойлоогүй.

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд туссан эсэх	Тайлбар
4.2.5 Хуульд заасан үнэ төлбөргүй, заавал суралцах СӨБ-ын хугацаа	Огт тусаагүй	“Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай” хуульд СӨБ-д 2-5 насны хүүхэд хамрагдах бөгөөд СӨБ-ыг 5 настай хүүхдэд заавал эзэмшүүлнэ гэж заасан байдаг.

*Эх сурвалж: ТХЗ-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд, ЮНЕСКО, 2015 он*

СӨБ-ын түвшинд хамран сургалт буюу хүртээмжийг түлхүү анхаарч сургуульд бэлтгэгдсэн байдал, эрүүл энх буюу хөгжлийн хувьд хэвийн өсөн торних зэрэг чанарын үзүүлэлтэд бага ач холбогдол өгч байгаа хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн, ТХЗ-4-т тусгагдсан үзүүлэлтүүдийг ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд зарим талаар агуулсан ч бүрэн нийцтэй гэж үзэхээргүй байгаа тул ТХЗ-ын үзэл баримтлалын дагуу хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг хүйс, насны бүлэг, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдээр ялган тайлагнах хэрэгтэй байна. Ингэж тайлагнахад манай улсын тоон мэдээллийн бэлэн байдал хангалтгүй байж болох тул мэдээллийн бэлэн болон найдвартай байдлыг хангах чиглэлээр мөн анхаарах нь зүйтэй.

### **Ерөнхий боловсрол**

БШУС-ын багцад багтаж буй төсвийн хөтөлбөрүүдийн нэг нь ерөнхий боловсрол (ЕБ)-ын хөтөлбөр ба энэ хүрээнд бага боловсрол, дунд боловсрол, суурь боловсрол, бүрэн дунд боловсролын асуудал багтаж байна. ЕБ-ын хувьд 2021 онд 8, 2022 онд 13, 2023 онд 11, 2024 онд 14 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг төсвийн тухай хуульд тусгасан.

*Хүснэгт 4. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
<b>Бага боловсрол</b>		
Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	60	-
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	66	-
Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь	98	-
Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар	98	-
<b>Дунд боловсрол</b>		
Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	63	50
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	56	41
Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	98	99.2
Сурах бичгийн хангалтын хувь	-	63
<b>Суурь боловсрол</b>		
Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо	-	401,200
Ахлах ангийн (10 дугаар) элсэлтийн хувь	82	92
Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	96	96
Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар	98	-
<b>Бүрэн дунд боловсрол</b>		
Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	511	518
Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элссэн суралцагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	96	98
18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	79	82
Дотуур байранд суух хүсэлтийн дагуу амьдарч байгаа суралцагчийн хувь	-	75

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

Тус хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд нэлээд өөрчлөгдсөн байна. Тодруулбал, 2023 онд бага боловсролын түвшинд ямар ч үр дүнгийн үзүүлэлт тодорхойлоогүй. 2021 оны 8 хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2022 онд тэр чигтээ хасагдаж, өөр 13 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тусгасан. 2022-2024 онд зөвхөн 7 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тогтвортой хэвээр хадгалагджээ. Дараах хүснэгтэд ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ЕБ-ын түвшинд сүүлийн 3 жилд хэр тогтвортой байсныг харуулав.

*Хүснэгт 5. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн тогтвортой байдал*

Үзүүлэлт	2022	2023	2024	Тайлбар
Хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тоо	13	11	14	2021 оны хувьд хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тоо 8 байсан.
Өмнөх онтой харьцуулахад хасагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тоо	8	5	1	
Өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тоо	13	3	4	
Өмнөх онтой харьцуулахад өөрчлөлт ороогүй хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тоо	0	8	10	2022 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд бүхэлдээ шинэчлэгдсэн.

*Эх сурвалж: Судалгааны багийн нэгтгэл*

2021 оны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд нь ЕБС-ийн тоо, суралцагчдын тоо, төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн суралцагчдын тоо гэх мэт орцын үзүүлэлтүүд байсан бөгөөд 2022 оноос илүүтэй үр дүнгийн үзүүлэлтүүдийг тусгахаар хичээсэн нь харагдаж байна. Хэдийгээр ерөнхий боловсрол гэсэн нэг төсвийн хөтөлбөрт багтаж байгаа, мөн тусад нь салгах ёстой биш ч 2022 оноос бусад жилүүдэд (2021 оны хувьд ерөнхий байдлаар тусгагдсаныг эс тооцвол) бага боловсролын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үзүүлэлт тухайн оны төсвийн хуулийн хавсралтад тусгагдаагүй. Тиймээс эдгээр үзүүлэлтүүдийн хувьд 2022, 2023 оныг өмнөх болон

дараах онтой нь харьцуулах боломжгүй юм. Доорх хүснэгтүүдэд ЕБ-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд манай улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, ТХЗ-ын үзүүлэлтүүдтэй хэр нийцтэй байгааг харуулав.

*Хүснэгт 6. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн “Алсын хараа-2050” бодлогын үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

№	Бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТХЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
1	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Зарим талаар тусгагдсан	Хамран сургалтын хувь, бохир жингээр гэсэн үзүүлэлт бий. Гэхдээ энэ хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2021 оны төсвийн хуульд тусгасан ба түүнээс хойш тусгагдаагүй байна.
2	7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	Зарим талаар тусгагдсан	Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь гэсэн 2 үзүүлэлт бий.
3	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшингээр)	Тусгагдаагүй	

*Эх сурвалж: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*

*Хүснэгт 7. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

№	Бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
1	Тоо, унших чадварын наад захын түвшнийг хангаж бага боловсрол эзэмшсэн хүүхэд, залуучуудын эзлэх жин, хүйсээр	Зарим талаар тусгагдсан	Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь 2022 оноос бусад онд тусгагдаагүй, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь 2022 оноос бусад онд тусгагдаагүй.
2	Тоо, унших чадварын наад захын түвшнийг хангаж суурь боловсрол эзэмшсэн хүүхэд, залуучуудын эзлэх жин, хүйсээр	Тусгагдсан	Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь гэсэн 2 үзүүлэлт бий.
3	Хамран сургалтын бохир жин, түвшин, хүйс, байршлаар	Зарим талаар тусгагдсан.	Хамран сургалтын хувь, бохир жингээр гэсэн үзүүлэлт бий. Гэхдээ энэ хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2021 оны төсвийн хуульд тусгасан ба үүнээс хойш тусгагдаагүй байна.
4	7-14 настай хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	Зарим талаар тусгагдсан	Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь гэсэн үзүүлэлтүүд тусгагдсан байдаг.
5	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, хүйсээр	Зарим талаар тусгагдсан	Хамран сургалтын хувь, бохир жингээр гэсэн үзүүлэлт бий. Гэхдээ энэ хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2021 оны төсвийн хуульд тусгасан ба үүнээс хойш тусгагдаагүй байна.

№	Бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
6	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, хүйсээр, хот хөдөөгөөр	Зарим талаар тусгагдсан	Хамран сургалтын хувь, бохир жингээр гэсэн үзүүлэлт бий. Гэхдээ энэ хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2021 оны төсвийн хуульд тусгасан ба үүнээс хойш тусгагдаагүй байна.

*Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030*

*Хүснэгт 8. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д тусгагдсан боловч ТЕЗ-ийн “Ерөнхий боловсрол” хөтөлбөрт тусгагдаагүй хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд*

№	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт
1	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшингээр)
2	Олон улсын суралцагчийн үнэлгээний хөтөлбөр буюу PISA-ийн үр дүн, хүйс, байршил, сургуулийн хэв шинжээр
3	Казах, тува суралцагчийн 12 дугаар ангийн төгсөлтийн монгол хэлний шалгалтын үндэсний дундаж, хүйсээр
4	5 дугаар ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математикийн хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр
5	9 дүгээр ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математикийн хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр
6	12 дугаар ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математикийн хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр
7	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо
8	Бага ангид элссэн тусгай хэрэгцээт суралцагчийн хамран сургалтын цэвэр жин, хүйс, байршлаар
9	Дунд ангид элссэн тусгай хэрэгцээт суралцагчийн хамран сургалтын цэвэр жин, хүйс, байршлаар
10	Түрээсийн төлбөрийн сангийн санхүүжилтээр нөхөн хэвлэсэн сурах бичгийн эзлэх жин
11	Бага боловсролын дотоод үр ашгийн коэффициент
12	Дунд боловсролын дотоод үр ашгийн коэффициент
13	Төрөлжсөн ахлах сургуулийн тоо

*Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030*



ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдээс нийт 11 үзүүлэлт нь ерөнхий боловсролтой холбоотой үзүүлэлтүүд байгаа юм. Эдгээр үзүүлэлтээс зөвхөн 1 үзүүлэлт ТЕЗ-ийн хүрэх үр дүнд тусгагдсан ба 5 үзүүлэлт зарим талаар тусгагдсан, 4 үзүүлэлт огт тусгагдаагүй байдалтай байна.

*Хүснэгт 9. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн ТХЗ-4-т тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт*

ТХЗ-4-т тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
4.1.1. (i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадварыг эзэмшсэн (a) 2/3-р анги, (b) Бага анги төгссөн, (c) Дунд анги төгссөн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр	Зарим талаар тусгагдсан	Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь (2022 оноос бусад онд тусгагдаагүй), математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь (2022 оноос бусад онд тусгагдаагүй) гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд бий.
4.1.2. Сургууль төгсөлтийн түвшин, боловсролын түвшнээр (хүйс, байршил, баялгийн квантилаар салгах)	Тусгагдсан	ТХЗ-4-ийн энэ үзүүлэлт нь БШУС-ын дараах хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй холбоотой: <ul style="list-style-type: none"> <li>- Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь (2022 оноос бусад онд тусгагдаагүй)</li> <li>- Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар (2022 оноос бусад онд тусгагдаагүй)</li> <li>- Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь</li> <li>- Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь</li> </ul>

ТХЗ-4-т тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
		<ul style="list-style-type: none"> <li>- Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар</li> <li>- Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элссэн суралцагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь</li> <li>- 18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь</li> </ul>
<p>4.1.6.Үндэсний хэмжээний сургалтын үнэлгээний зохион байгуулалт а.2 ба 3-р анги, б.бага боловсролын төгсгөлд с.дунд боловсролын төгсгөлд</p>	<p>Зарим талаар тусгагдсан</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж</li> <li>- Ерөнхий шалгалтын анхны онооны дундаж гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй холбоотой.</li> </ul>
<p>4.6.1 Тухайн насны бүлгийн хүмүүсийн дотор (а) бичиг үсгийн болон (б) тоо тооллын анхан шатны үйлдлийн наад захын мэдлэг, чадвартай хүн амын эзлэх хувь, хүйсээр</p>	<p>Зарим талаар тусгагдсан</p>	<p>ТХЗ 4-ийн энэ үзүүлэлт нь БШУС-ын дараах хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй холбоотой:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь (2022 оноос бусад онд тусгагдаагүй)</li> <li>- Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь (2022 оноос бусад онд тусгагдаагүй)</li> <li>- Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь</li> <li>- Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь.</li> </ul>

ТХЗ-4-т тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
4.а.1 (а) Цахилгаан эрчим хүчинд холбогдсон; (b) сургалтын зорилгоор ашиглах интернэттэй; (c) сургалтын зорилгоор ашиглах компьютертэй; (d) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дэд бүтэц, сургалтын материалаар хангагдсан, (e) ундны усаар хангагдсан; (f) эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн байгууламжтай; (g) гар угаах өрөөтэй (WASH үзүүлэлтийн тодорхойлолтын дагуу) сургуулиудын эзлэх хувь	Зарим талаар тусгагдсан	ТХЗ-4-ийн энэ үзүүлэлт нь БШУС-ын дараах хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй холбоотой: <ul style="list-style-type: none"> <li>- Цахим платформуор дамжуулж явуулдаг хичээл</li> <li>- Цахим сургалтад хамрагдах ерөнхий боловсролын суралцагч</li> <li>- Нэг компьютерт ногдох хүүхэд гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй холбоотой.</li> </ul>

*Эх сурвалж: ТХЗ-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд, ЮНЕСКО, 2015 он*

*Хүснэгт 10. ТХЗ-4-ийн үр дүнгийн үзүүлэлтүүдээс ТЕЗ-ийн “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнд тусгагдаагүй үзүүлэлтүүд*

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Тайлбар
4.1.0. Ирээдүйд бэлтгэгдсэн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр	
4.1.3. Сургуульд элсэгчдийн хувь, сүүлийн ангиар, (бага боловсрол, дунд боловсрол)	
4.1.4. Сургууль завсардсан хувь (бага боловсролоос нэг жилийн өмнө, бага боловсрол, дунд боловсрол, бүрэн дунд боловсрол)	
4.1.5. Нас нь хэтэрсэн хүүхдийн эзлэх хувь (бага боловсрол, дунд боловсрол)	

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Тайлбар
4.1.7.а Үнэ төлбөргүй, б.заавал бага дунд боловсрол эзэмшсэн жилийн тоо хууль эрх зүйн орчноор баталгаажсан байдал	Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн “7/сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 4.1.”Сургуулийн өмнөх боловсролыг дөрөв, бага боловсролыг тав, суурь боловсролыг ес, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ.” гэж заасан.
4.5.1 Энэ жагсаалтад орсон боловсролын бүх үзүүлэлтийн задаргаагаар гарах тэнцвэрт байдал (паритет)-ын индекс (эрэгтэй/эмэгтэй, хот/хөдөө орон нутгийн, баян чинээлэг/ядуу, доогуур орлоготой бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй, мөргөлдөөнд өртсөн гэх зэрэг)	Одоогоор хүйсийг эс тооцвол ангилсан мэдээлэл харуулахгүй байгаа.

*Эх сурвалж: ТХЗ-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд, ЮНЕСКО, 2015 он*

“Алсын хараа-2050” болон “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д тусгагдсан зарим үр дүнгийн үзүүлэлтүүд ТЕЗ-ийн үр дүнгийн үзүүлэлтүүдэд тусгалаа олоогүй байна. Хэдийгээр Төсвийн тухай хуульд бүх шалгуур үзүүлэлтүүд бус харин гол шалгуур үзүүлэлтүүдийг тусгах боловч төсвөөс хөрөнгө нэлээд зарцуулдаг үйл ажиллагаанд хамааралтай хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг онцгойлон тусгах шаардлагатай. Тухайлбал, боловсролын салбарын хөрөнгө оруулалтад өндөр хувь эзэлдэг сургуулийн барилга барих, өргөтгөл барих ажлуудтай шууд холбоотой үзүүлэлт болох бүлэг дүүргэлтийн талаар хүрэх үр дүнгийн үзүүлэлт ТЕЗ-ийн үр дүнд тусгагдаагүй байна.

Түүнчлэн ТХЗ-ын үзүүлэлтүүдтэй илүү нийцтэй байлгах зорилгоор хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг хүйс, насны бүлэг, газар зүйн байршил, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдээр ангилан тайлагнах хэрэгтэй. Энэ тохиолдолд мөн л мэдээллийн бэлэн байдал хөндөгдөх нь гарцаагүй юм.

## Мэргэжлийн боловсрол, сургалт

Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)-ын хувьд 2022 онд 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй байсан бол 2023 онд 2 болжээ.

*Хүснэгт 11. “Мэргэжлийн боловсрол, сургалт” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь	1.87	58
Мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага хангасан орчин бүхий сургалтын байгууллагын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор засвар үйлчилгээ хийсэн барилга, байгууламж, дотуур байрны тоо	-	13
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	68	-
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь	10	-

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

Дээрх хүснэгтээс үзэхэд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд 2022, 2023 онд нэлээд ялгаатай тодорхойлогдсон байдалтай байгаа ч угтаа ижил үзүүлэлтийг ялгаатай байдлаар тооцоолжээ. Тодруулбал, “мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага хангасан орчин бүхий сургалтын байгууллагын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор засвар үйлчилгээ хийсэн барилга, байгууламж, дотуур байрны тоо” болон “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь” гэсэн 2 үзүүлэлт нь нэг нь тоогоор, нөгөө нь хувиар илэрхийлэгдсэн боловч үнэн хэрэгтээ ижил агуулгатай үзүүлэлтүүд юм. “Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь” гэсэн МБС-ын тогтолцооны хүрэх үр дүнгийн ихээхэн чухал үзүүлэлтийг 2023 онд хассан байна.

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлого болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “нийт төгсөгчдөд ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь” гэсэн үзүүлэлт мэргэжлийн боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлт байгаа бөгөөд БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан байсан ч 2023 онд хасагдсан.

Харин “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” баримт бичигт МБС-ын түвшинд чанар, хүртээмж, удирдлагын чиглэлээр нийт 16 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдсан байдгаас ердөө дараах 3 үзүүлэлт л их, бага хэмжээгээр ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байна. Үүнд:

- МБС-ын хөтөлбөрөөр суралцсан хүний эзлэх хувь (100 мянган хүнд),
- Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчийн эрэлтийн дагуу сургалтын тоног төхөөрөмж, бааз суурийг бэхжүүлсэн сургалтын байгууллагын тоо,
- МБС-ын хотхон сургууль төгсөгчдийн мэргэжлээр хөдөлмөр эрхлэлтийн хувь.

Харин чанар, хүртээмж, удирдлагатай холбоотой дараах чухал үзүүлэлтүүд БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт биш тул тэдгээрийн өөрчлөлтийг хянаж чадахгүй байна. Үүнд:

- Суурь боловсрол төгсөгчдөөс МБС-ын хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын эзлэх хувь,
- Богино хугацааны сургалтаар мэргэжлийн ур чадвар эзэмшсэн, мэргэшил дээшлүүлсэн 15-аас дээш насны иргэдийн ажилгүйдлийн түвшин,
- Давтан сургалтад хамрагдаж, мэргэшил дээшлүүлсэн багшийн нийт багшид эзлэх хувь,
- Нээлттэй, зайн сургалтын хөтөлбөрөөр суралцаж буй 24-64 насны суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь,
- Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын тоо.

Дараах хүснэгтээр МБС-тай шууд холбоотой ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрээс ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдэд тусгагдсан байдлыг харуулав.

*Хүснэгт 12. ТХЗ-4, БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцэл*

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсан эсэх	Тайлбар
4.3.1 Залуус, насанд хүрэгчдийн өнгөрсөн 12 сарын хугацаанд албан ба албан бус боловсрол, сургалтад хамрагдсан хувь	Тусгагдаагүй	
4.3.1 Техник, мэргэжлийн боловсролд хамрагдалтын хувь	Туссан	“Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт тохирч байна.
4.4.3 Залуус/насанд хүрэгчдийн боловсролын түвшин	Тусгагдаагүй	

*Эх сурвалж: ТХЗ-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд, ЮНЕСКО, 2015 он*

МБС-ын түвшинд хүртээмж буюу хамран сургалт, сургалтын орчин нөхцөлийг авч үзээд мөн л чанар, тогтолцооны үр дүнгийн үзүүлэлтүүд болох хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн хувь зэргийг орхигдуулж байна.

## Дээд боловсрол

“Дээд боловсрол” (ДБ) хөтөлбөрийн тухайд 2022 онд 4 хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй байсан бол 2023 онд 5 үзүүлэлттэй болсон нь 2023 онд “дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо” гэсэн үзүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой юм. Харин “тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2022 онд зөвхөн багш, сувилагч мэргэжлээр хязгаарлаж байсан бол 2023 онд ямар нэгэн мэргэжил заасан хязгаарлалтыг байхгүй болгожээ.

*Хүснэгт 13. “Дээд боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Их, дээд сургуулийн тоо	88	86
Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	500	500
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо	-	4,000
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо (багш, сувилагч)	3,727	-
Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо	15,000	15,000
Дотоодын болон гадаадын их, дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо	-	400

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

Дээрх үзүүлэлтүүд мөн л дээд боловсролын тогтолцооны хүрэх үр дүн гэхээс илүү нөөцийн тоо хэмжээг илэрхийлсэн үзүүлэлтүүд байгаа бөгөөд дээд боловсролын салбарт улсын төсвөөс төлбөрийн хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээлээс өөр санхүүжилт өгөхгүй байгааг илтгэж байна.



Дээд боловсролын түвшинд “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогод “нийт төгсөгчдөд ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “дээд боловсролын нийт багшид докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь”, “ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь” гэх зэрэг дээд боловсролын чанарыг илэрхийлэхэд илүү тохиромжтой хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд тусгагдсан байдаг ч БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт биш байгааг анхаарч, нийцүүлэх хэрэгтэй.

“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” баримт бичигт ДБ-ын түвшинд чанар, хүртээмж, удирдлагын чиглэлээр нийт 8 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдсан байдаг. Тухайлбал, “дээд боловсролын нийт багшид эзлэх докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь”, “төгсөгчдийн хөдөлмөрийн эрхлэлтийн түвшин”, “хөдөө орон нутгийн оюутны эзлэх хувь” зэрэг ДБ-ын тогтолцооны чанар, хүртээмжийг илэрхийлсэн чухал үзүүлэлтүүдийн аль нь ч БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдаагүй байгааг мөн анхаарах шаардлагатай юм.

Дараах хүснэгтээр дээд боловсролтой шууд холбоотой ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрээс БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдэд тусгагдсан байдлыг харуулав.

*Хүснэгт 14. ТХЗ-4-ийн үр дүнгийн үзүүлэлтээс БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдаагүй үзүүлэлтүүд*

ТХЗ-4-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Тайлбар
4.3.1 Залуус, насанд хүрэгчдийн өнгөрсөн 12 сарын хугацаанд албан ба албан бус боловсрол, сургалтад хамрагдсан хувь	
4.3.2 Дээд боловсролд хамрагдалтын бохир жин	Манайд зөвхөн их, дээд сургуулийн тоог авч үздэг.
4.4.3 Залуус/насанд хүрэгчдийн боловсролын түвшин	

*Эх сурвалж: ТХЗ-ын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд, ЮНЕСКО, 2015 он*

“Дээд боловсрол” хөтөлбөрийн хувьд манай улс хүртээмж, чанар зэрэг асуудлыг огт авч үздэггүй бөгөөд зөвхөн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулсан болон санхүүгийн дэмжлэг авсан оюутны тоогоор хөтөлбөрийн үр дүнг хэмждэг. Энэ нь өмнө нь дурдсанчлан, дээд боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгийг зарцуулж байгаа хэсгээр зөвхөн хязгаарлагдаж байгааг илтгэж байгаа юм.

### Насан туршийн боловсрол

2022, 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтад туссан “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 15. “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь	15	-
Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо	-	15,000
Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо	5,068	5,430

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 онд “бичиг үсэг, тоо тооллын хэрэглээний чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах хүний тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт байсан бол 2022 оноос тус үзүүлэлт хасагдсан. 2023 онд 2022 оны “мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь” гэсэн үзүүлэлт нь “цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо” гэж өөрчлөгдсөн нь хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийг харьцуулан дүгнэхэд хүндрэлтэй болгож байна. Харин

“Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт сүүлийн дөрвөн жил өөрчлөлтгүйгээр ашиглагдаж байгаа юм.

Дээрх үзүүлэлтүүдийг ТХЗ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд туссан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байгаа эсэхийг харьцуулахад “Алсын хараа-2050” болон таван жилийн үндсэн чиглэлд “насан туршийн боловсрол” хөтөлбөрт хамаарах хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд тусаагүй байна. Харин ТХЗ-ын 4.4.1-т “Мэдээлэл харилцаа холбоо, технологийн ур чадвартай насанд хүрэгсэд болон залуучуудын эзлэх хувь, ур чадварын төрлөөр” гэсэн үзүүлэлт туссан байдаг.

*Хүснэгт 16. “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

Тогтвортой хөгжлийн зорилгод туссан байдал	“Алсын хараа 2050”-д туссан байдал	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан байдал	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан байдал
Мэдээлэл харилцаа холбоо, технологийн ур чадвартай насанд хүрэгсэд болон залуучуудын эзлэх хувь, ур чадварын төрлөөр	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Нээлттэй зайн сургалтад хамрагдсан иргэдийн тоо
Анхан шатны дижитал ур чадварыг эзэмшсэн залуучууд болон насанд хүрэгчдийн эзлэх хувь			Өмнөх мэдлэг ур чадварыг хүлээн зөвшөөрч олгосон гэрчилгээний тоо
Залуучууд болон насанд хүрэгсдийн боловсрол эзэмшилтийн хувь насны бүлэг болон боловсролын түвшнээр			

*Эх сурвалж: “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, ЮНЕСКО*

Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2022, 2023 онд мөн л тогтвортой бус байсан. Зарим үзүүлэлт агуулгын хувьд төстэй ч өөр үзүүлэлтээр солигдсон байгаа нь үр дүнг нь харьцуулах, дүгнэлт хийхэд төвөгтэй байдал үүсгэж байсан. Манай улсын хөгжлийн урт, дунд хугацааны баримт бичгүүдэд насан туршийн боловсролтой холбоотой хүрэх дүнг тусгаагүй байгааг мөн анхаарах хэрэгтэй. Түүнчлэн насан туршийн боловсролыг зөвхөн цахим ур чадвар олгох сургалтаар хязгаарлаж байгаа нь насан туршийн боловсролын үзэл баримтлалтай төдийлөн тохирохгүй юм.

## Сургалтын биет орчин

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтад сургалтын биет орчны хөтөлбөрийн дараах 4 чанарын болон тоон үзүүлэлтүүдийг тусгажээ.

*Хүснэгт 17. “Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо	25	-
Интернэтэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь	60	
Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	42	
Хүчин чадал ашиглалтын хувь	140	

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

Эдгээр хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2021 оны төсвийн тухай хуулийн хавсралтад байгаагүй бөгөөд 2022 оны төсвийн тухай хуульд шинээр нэмэгдэн орж ирсэн юм. Гэвч тус хөтөлбөр нь 2023, 2024 оны төсөвт үргэлжлэн тусгагдалгүй хасагдсан байна. Харин “сургалтын нэг компьютерыг ашиглах суралцагчийн тоо” гэсэн үзүүлэлт 2024 оны улсын төсвийн тухай хуулийн хавсралтад “Ерөнхий боловсрол”

хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт байдлаар тусгагджээ. Дээрх хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдээс харахад ЕБС-ийн биет орчны талаарх үзүүлэлтүүдийг тусгасан боловч СӨБ-ын биет орчин зэргийг орхигдуулсан байгааг харж болно.

Тус хөтөлбөртэй холбоотой хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд “Алсын хараа-2050” болон таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Харин тогтвортой хөгжлийн зорилгын 4.а.1-д сургалтын орчинд хамаарах тодорхой хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд туссан байгааг үзэхэд ТЕЗ-ийн хөтөлбөрт сургалтын биет орчны талаар хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ТХЗ-4-тэй зарим талаар уялдсан байдалтай байна.

*Хүснэгт 18. “Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

Тогтвортой хөгжлийн зорилгод туссан байдал	“Алсын хараа 2050”-д туссан байдал	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан байдал	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан байдал
(а) Цахилгаан эрчим хүчинд холбогдсон; (б) Сургалтын зорилгоор ашиглах интернэттэй; (в) Сургалтын зорилгоор ашиглах компьютертэй; (г) Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан дэд бүтэц, сургалтын материалаар хангагдсан; (д) Ундны усаар хангагдсан; (е) Эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн байгууламжтай; (ж) Гар угаах өрөөтэй сургуулиудын эзлэх хувь.	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	ЕБС-ийн барилга, байгууламж, дотуур байрны нэмэлт суудлын тоо  Гадаа бие засах газартай ЕБС-ийн эзлэх жин

*Эх сурвалж: “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, ЮНЕСКО*

“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д ЕБС-ийн дэд бүтэц, барилга байгууламжийг сайжруулахтай холбоотой арга хэмжээнүүд тусгагдсан бөгөөд үр дүнг нь ЕБС-ийн барилга, байгууламж, дотуур байрны нэмэлт суудлын тоо, гадаа бие засах газартай ЕБС-ийн эзлэх жин зэргээр илэрхийлсэн байгаа нь ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй төдийлөн нийцгүй байна.

### *Тусгай хэрэгцээт боловсрол*

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтад тусгай хэрэгцээт боловсролтой холбоотойгоор “сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн тусгай сургуульд хамран сургалтын хувь” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тусгасан. 2022 онд ямар нэгэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдаагүй байсан бол 2021 онд ЕБ-ын хөтөлбөрт “ерөнхий боловсролын тусгай хэрэгцээт сургуульд хамрагдах хүүхдийн тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт орсон.

Харин 2024 онд “Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн хүрээнд дараах 5 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлжээ. Үүнд:

- СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувь (2-5 насны сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нийт хүүхдэд эзлэх жин);
- Ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувь (6-18 насны ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдэд эзлэх жин);
- Мэргэжлийн болон техникийн боловсролд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь (15-45 насны мэргэжлийн болон техникийн боловсролд суралцсан нийт хүн амд эзлэх жин);
- Дээд боловсролд эрх тэгш оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувь (18-45 насны дээд боловсролд суралцсан нийт хүн амд эзлэх жин);
- Насан туршийн суралцахуйн төвд боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь (2-45 насны

насан туршийн суралцахуйн төвд боловсролын үйлчилгээнд хамрагдсан нийт хүн амд эзлэх жин).

Ингэснээр бүх түвшний боловсролын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн хэр зэрэг хамрагдаж байгаа буюу хүртээмжийг тодорхойлох боломжтой болсон нь сайшаалтай хэрэг ч угтаа бол тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөр гэж тусдаа хөтөлбөр, хүрэх үр дүн тодорхойлохгүйгээр холбогдох хөтөлбөрт тусгах хэрэгтэй. Энэ нь тусгай хэрэгцээт буюу хүртээмжтэй боловсролын үзэл баримтлалтай ч нийцтэй болох юм.

“Алсын хараа-2050” болон таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт тусгай хэрэгцээт боловсролтой холбоотой хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдаагүй байна. Харин ТХЗ-ын боловсролын чанарыг хэмжих бүхий л хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг эрэгтэй, эмэгтэй, хот, хөдөө, орон нутгийн, баян чинээлэг, ядуу, доогуур орлоготой, бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үзүүлэлтээр ялгаж тайлагнах тухай заасан байдаг. Ингэж эрх тэгш байх, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хэрэгжилтийг хангах юм.

*Хүснэгт 19. “Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

Тогтвортой хөгжлийн зорилгод туссан байдал	“Алсын хараа 2050”-д туссан байдал	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан байдал	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан байдал
Чанартай боловсролыг дэмжих бүлэгт орсон боловсролын чанарыг хэмжих бүхий л шалгуур үзүүлэлтүүдийг эрэгтэй, эмэгтэй, хот, хөдөө,	Тусгагдаагүй	Тусгагдаагүй	Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн СӨБ, бага, дунд ангид хамран сургалтын бохир жин, хүйсээр Тохируулгат сургалтын хөтөлбөрөөр, тохируулгат орчинд суралцсан тусгай хэрэгцээт иргэдийн нийт суралцагчдад эзлэх хувь

Тогтвортой хөгжлийн зорилгод туссан байдал	“Алсын хараа 2050”-д туссан байдал	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан байдал	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан байдал
орон нутгийн, баян чинээлэг, ядуу, доогуур орлоготой, бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үзүүлэлтээр ангилах			Тохируулгат орчин бүрдсэн ЕБС-ийн эзлэх жин, байршлаар, хэв шинжээр
			Тусгай хэрэгцээт хүүхдэд чиглэсэн сургалтын батлагдсан модулийн тоо
			Тусгай хэрэгцээт хүүхдэд хичээл заадаг багшийн тоо болон эзлэх жин, хүйсээр, хичээлээр, түвшнээр, байршлаар
			Тохируулгат сургалтын хөтөлбөрөөр, тохируулгат орчинд суралцсан тусгай хэрэгцээт иргэдийн нийт суралцагчдад эзлэх хувь нэмэгдсэн

*Эх сурвалж: “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”.*

“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д тусгай хэрэгцээт боловсролын хамран сургалтын хувийг сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын ангиллаар тус бүр тусгаснаас гадна тохируулгат орчин, тохируулгат хөтөлбөр бүхий сургалтын орчин, мөн тусгай хэрэгцээт иргэдийн хувийг мэргэжлийн болон насан туршийн боловсролын түвшинд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдээр тодорхойлсон байгааг ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд тусгах шаардлагатай гэж үзэж байна. Энэ тохиолдолд мэдээллийн бэлэн байдал болон найдвартай байдлын асуудал хөндөгдөнө.



## Шинжлэх ухаан, технологи

Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрээнд дараах чанарын болон тоон үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

*Хүснэгт 20. “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, зорилтот түвшин, 2022-2023 он*

Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2022 он	2023 он
Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын ДНБ-д эзлэх хувь	0.18	0.2
Судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо	-	1,400
Хэвлүүлсэн бүтээлийн тоо (дотоод, гадаадад)	13,000	11,000
Инновацийн тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцсон ажиллагчид, иргэдийн тоо (6 тэргүүлэх чиглэл, 11 технологийн хүрээнд)	-	650
Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	250	-

- Уг үзүүлэлт тухайн жилд байгаагүй.

*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2023 он*

2023 онд зөвхөн 2 үзүүлэлтийг хэвээр хадгалж, 2 үзүүлэлт нэмсэн төдийгүй “боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг хасчээ.

“Алсын хараа-2050” болон таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт туссан “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрт хамаарах хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд нь ТЕЗ-ийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байсан бол “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д “шинжлэх ухаан, технологийн парк байгуулах, стратеги, төлөвлөлт батлагдсан байна” гэсэн ганц чанарын үзүүлэлт байна.

*Хүснэгт 21. “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал*

Тогтвортой хөгжлийн зорилгод туссан байдал	“Алсын хараа 2050”-д туссан байдал	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан байдал	“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-д туссан байдал
Холбогдох зорилт болон шалгуур үзүүлэлт тусгагдаагүй	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Шинжлэх ухаан, технологийн парк байгуулах стратеги, төлөвлөлт батлагдсан байна.
		Нэг сая хүнд ногдох эрдэм шинжилгээний өгүүллийн тоо	
		Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан бүтээлийн тоо	

*Эх сурвалж: “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, ЮНЕСКО*

Дээрх байдлаас харахад, шинжлэх, ухаан технологийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд туссан үр дүнгүүдтэй нийцтэй байна.

## Бүлгийн дүгнэлт

Энэ бүлэгт 2022, 2023 оны төсвийн тухай хуульд заасан БШУС-ын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн томъёолол, тогтвортой байдал, тэдгээрийн ТХЗ-4 болон Монгол Улсын хөгжлийн бусад баримт бичгүүдэд тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байгаа эсэхийг авч үзэхэд дараах нийтлэг байдал ажиглагдаж байна. Үүнд:

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ихэнхдээ тогтвортой биш байна. Түүнчлэн томъёолол нь өөрчлөгдөх тохиолдлууд байна. Жишээлбэл, “5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь” гэсэн үзүүлэлт “сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь” гэсэн үзүүлэлттэй агуулгын хувьд ижил ч өөр үзүүлэлт мэтээр томъёологджээ.
- 2021 онтой харьцуулахад 2022, 2023 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлтээр илүүтэй гарцын буюу үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд тодорхойлсон нь тун сайшаалтай хэрэг юм. Энэ нь сүүлийн үед төсөв, бодлогын уялдааг сайжруулж, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг дэмжиж байгаатай холбоотой гэж үзэхээр байна. Жишээ татахад 2021 онд ЕБС-ийн сургуулийн тоо, төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн суралцагсдын тоо гэх зэрэг орцын үзүүлэлтүүдийг авч үздэг байсан бол 2022, 2023 онд хамран сургалтын хувь, сургалтын чанар зэрэг боловсролын хүртээмж төдийгүй чанартай холбоотой хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг тусгах болжээ.
- Хэдий тийм ч ТХЗ-4, “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө” зэрэг бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүлэг дүүргэлт, хөдөлмөр эрхлэлт, жендэр, эрх тэгш байдлыг илэрхийлсэн чухал хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд тусгалаа олохгүй байгаад анхаарч, улсын төсвийн хөрөнгийг зарцуулснаар хүрэх үр дүнг эрх тэгш байдлыг хангасан, хэнийг ч орхигдуулахгүй

байх зарчимтай нийцүүлэн илүү оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

- ТХЗ-4, “Алсын хараа-2050”, болон бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдтэй нийцтэй байдлаар ТЕЗ-дын хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг сонгох шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй.
- Үндэсний бодлогын баримт бичиг болон олон улсын жишигт туссан үр дүнгийн үзүүлэлтүүдийг авч үзэх тохиолдолд мэдээллийн бэлэн байдал болон найдвартай байдлын асуудал үүсэхээр байна. Тухайлбал, хамран сургалтын үзүүлэлтүүдийг хот хөдөө, өрхийн амьжиргааны түвшин, шилжин ирэгсэд зэргээр ангилсан тоон мэдээлэл тэрбүрийд бэлэн байдаггүйгээс гадна шууд шийдвэр гаргахад ашиглахуйц найдвартай мэдээлэл ховор байгаа юм.

#### **4. БШУЯ-НЫ 2022-2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ДУРДСАН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**


##### **2022-2023 оны сайдын багцын төсвийн хуваарилалт, гүйцэтгэл ба хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт**

БШУС-ын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3.27 их наяд, үйл ажиллагааны орлогоос 2.5 тэрбум, эргэн төлөгдөх зээлээс дамжуулан зээлд татуулахаар 3.5 тэрбум төгрөгийг, нийт зарлагыг 3.27 их наяд төгрөгөөр тооцон төлөвлөж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлжээ. Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 326 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 588.6 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 33.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар нийт зардлыг 2,321,249.2 сая төгрөгөөр баталсан байна. Дараа нь Засгийн газрын 2022 оны “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 393 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайдын 2022 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 75.5 тэрбум төгрөгөөр бууруулж 2.2 их наяд төгрөг болгон өөрчилжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2.2 их наяд төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 42 тэрбум,

хөрөнгийн зардлыг 83.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан, урсгал төсвөөс төлөвлөгөөнд батлагдаагүй 20.2 тэрбум төгрөгийн оюутны зээл гаргасантай холбоотой байна. Дараах зурагт 2022 оны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө ба гүйцэтгэлийг харуулав. (2022 оны хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 35-аас харна уу.)

*Зураг 1. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2022 он*



Эх сурвалж: Үндэсний аудитын газар (ҮАГ)


Дээрх зургаас харахад 2022 онд “Дээд боловсрол” болон “Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага” гэсэн 2 хөтөлбөрөөс бусад бүх хөтөлбөрийн төсөв бүрэн зарцуулагдаагүй байна. Тодруулбал, “Шинжлэх ухаан технологи” гэсэн хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл 83 хувьтай байсан бол “Мэргэжлийн боловсрол” болон “Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ” гэсэн 2 хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл тус бүр 92 хувьтай байжээ.

Харин 2023 онд БШУС-ын төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6.57 их наяд төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5.6 тэрбум төгрөг, нийт зарлагыг 6.57 их наяд төгрөгөөр

тооцон төлөвлөж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхэд төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 1.2 их наяд төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 2.2 их наяд төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 40.8 тэрбум төгрөгөөр бууруулж, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар нийт зардлыг 3.1 их наяд төгрөгөөр баталсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4.98 их наяд төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь урсгал зардлын төсвийг 315 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Дараах зурагт 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө ба гүйцэтгэлийг харуулав (2023 оны хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 36-аас харна уу).

*Зураг 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2023 он*



Эх сурвалж: УАГ

2022 онтой харьцуулахад 2023 онд үндсэндээ бүх хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл өсжээ. Тэр дундаа “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Гэсэн хэдий ч СӨБ, “Тусгай хэрэгцээт боловсрол” гэсэн 2 хөтөлбөрийг эс тооцвол төсвийн гүйцэтгэл 76-99 хувьтай байжээ. Өөрөөр хэлбэл нэмэгдсэн төсвийг бүрэн зарцуулж чадаагүй дүр төрх ажиглагдаж байна.

Дараах хүснэгтээр тус ТЕЗ-ийн төсвийн багцын хуваарилалт, хөтөлбөрт хамаарах үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэлийн дунджийг харуулав.

*Хүснэгт 22. Төсвийн хуваарилалт ба хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт, 2022-2023 он*

Хөтөлбөр	Сайдын багцын төсвийн хуваарилалт, хөтөлбөрөөр			Үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт (дунджаар)		
	2022 он	2023 он	Өөрчлөлт	2022 он	2023 он	Өөрчлөлт
Сургуулийн өмнөх боловсрол	25.1%	24.7%	-0.4	114.9%	99.8%	-15.1
Ерөнхий боловсрол	65.3%	64.6%	-0.7	95.6%	103.0%	7.4
Дээд боловсрол	1.8%	2.2%	0.3	96.0%	74.5%	-21.5
Мэргэжлийн боловсрол	3.9%	5.2%	1.3	327.8%	100.0%	-227.8
Насан туршийн боловсрол	0.2%	0.3%	0.03	100.8%	97.3%	-3.5
Сургалтын биет орчин	0.0%	0.0%	0.0	100.8%	-	-
Тусгай хэрэгцээт боловсрол	0.0%	0.2%	0.2	-	100.0%	-
Шинжлэх, ухаан технологи	3.6%	2.9%	-0.8	72.3%	92.8%	20.5


*Эх сурвалж: БШУЯ, СЯ*

БШУС-ын төсөвт ЕБ-ын төсөв мэдэгдэхүйц их хувийг эзэлж, удаад нь СӨБ-ын хөтөлбөрийн төсөв орж байна. Уг хоёр хөтөлбөрт нийт төсвийн 90 орчим хувийг зарцуулдаг. СӨБ-ын хүрэх үр дүнгийн



үзүүлэлтүүдийн биелэлтийн дундаж 2022 онд 114.9 хувь байсан бол 2023 онд 99.8 хувь болж буурчээ. Харин ЕБ-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн дундаж мөн хугацаанд 95.6 хувиас 103 хувь болж сайжирсан. “Дээд боловсрол” болон “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн төсөв нэмэгдэж, сайдын багцад эзлэх хувь нь нэмэгдсэн ч холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн дундаж хувь буурсан байгаа нь харин анхаарал татахаар байна. “Дээд боловсрол” хөтөлбөрийн хувьд 21.5 пунктын бууралттай байгаа нь нэг талаар 2023 онд хөтөлбөрийн төсвөө бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байж болох ч төсвийн гүйцэтгэл нь 2022-2023 онд 14.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаатай харьцуулахад чамлалттай үзүүлэлт юм. Харин “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийн дундаж 2023 онд 100 хувь байгаа хэдий ч 2022 онд 327.8 хувь байсантай харьцуулахад буурсан байдалтай байна.

*Зураг 3. Төсвийн хуваарилалт ба хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт, өөрчлөлтөөр, 2022-2023 он*



Эх сурвалж: БШУЯ, СЯ

Сайдын багцын төсвийн хуваарилалт өссөн, “Дээд боловсрол”, “Мэргэжлийн боловсрол” “Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрүүдийн үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт буурсан эсхүл огт өөрчлөгдөөгүй, мөн төсвийн хуваарилалт буурсан “Ерөнхий боловсрол” “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хувьд эсрэгээрээ үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт сайжирсан байгаагаас харахад төсвийн хуваарилалтын хувь хэмжээ болон үр дүнгийн биелэлт хоёрын хооронд хамаарал буй эсэхийг нэгэн утгатай дүгнэх боломжгүй байна. Түүнчлэн 2022 онтой харьцуулахад 2023 онд үндсэндээ бүх хөтөлбөрийн батлагдсан төсөв, гүйцэтгэл нь нэмэгдсэн ч СӨБ, “Дээд боловсрол”, “Мэргэжлийн боловсрол”, “Насан туршийн боловсрол” зэрэг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийн дундаж хувь буурсан байгаа нь хүрэх үр дүн болон батлагдсан төсөв бодит уялдаатай эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байгаа юм.


## **Хүрэх үр дүнгийн гүйцэтгэл ба төсвийн зарцуулалт**

### *Сургуулийн өмнөх боловсрол*

СӨБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн хувьд суурь түвшин, зорилтот түвшнийг хэдэн оны үзүүлэлтээр тооцох, өнгөрсөн оны бодит түвшин тооцогдсоны дараа жилийнх нь зорилтот түвшнийг өөрчлөх хэрэгтэй эсэх зэрэг олон эргэлзээтэй асуудал байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь гэсэн үзүүлэлт 2022 онд хэдийнэ 90 хувьд хүрсэн гэж тайлагнасан атал 2023 онд зорилтот түвшнийг 88.5 хувь, 2024 онд 87 хувь гэж тус тус тодорхойлсон байгаа нь хүрсэн түвшнээс бууруулах зорилттой байгаа мэт ойлгогдохоор байна. Түүнчлэн уг үзүүлэлтийн хувьд 2023, 2024 оны аль алинд суурь түвшнээр 2021 оны хүрсэн түвшнийг сонгосон хэр нь харгалзан 62.5 хувь, 77.8 хувь гэсэн ялгаатай үр дүнг бичжээ. Таван настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь 2021 онд 91.3 хувиас 93 хувь хүрсэн байтал 2022 оны зорилтот түвшнийг 86 хувь гэж тодорхойлсон. Энэ нь 2022 оны төсвийг бэлтгэж байхад 2021 оны тоон мэдээлэл бэлэн болоогүй байсантай зарим талаараа холбоотой ч хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо


өмнөх хугацааны зорилтын биелэлт, хүлээгдэж буй гүйцэтгэл, биелэх боломж зэргийг төдийлөн харгалздаггүй юм байна гэж дүгнэхэд хүрч байна. Түүнчлэн СӨБ-ын хамран сургалтын хувь гэсэн үзүүлэлтийн хувьд жил тус бүрийн зорилтот түвшнийг ажиглахад биелүүлэхэд хялбар зорилтыг дэвшүүлээд байна уу гэхээр түвшнийг тодорхойлсон байдал байгаа юм.

*Зураг 4. “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он*



*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он*

Зураг 5. “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2022-2024 он




Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он

ТЕЗ-ийн СӨБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт-27-оос дэлгэрэнгүй харна уу.

2022 онд СӨБ-ын салбарт 563.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 548.2 тэрбум төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 97.2 хувь байсан бол 2023 онд 767.8 тэрбум төгрөгийн төсөв батлагдсаны 99.5 хувь буюу 764.1 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Дараах зурагт СӨБ-ын салбарын 2022-2023 оны төсөв, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийг харуулж байна.

Зураг 6. “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт



Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол

2022-2023 онд СӨБ хөтөлбөрийн батлагдсан төсөв 203.8 тэрбум төгрөгөөр, зарцуулалт нь 215.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн гүйцэтгэл 2.3 пунктээр сайжирсан ч хүрэх дүнгийн 1 үзүүлэлтийн биелэлтийг сайжруулах шаардлагатай байсан. Тодруулбал, СӨБ-ын хүртээмжийг илэрхийлэх үзүүлэлт болох 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь гэсэн үзүүлэлтийн биелэлт 98 хувийн гүйцэтгэлтэй буюу зорилтот түвшиндээ хүрээгүй тул сайжруулах шаардлагатай гэсэн ангилалд орууллаа.


## Ерөнхий боловсрол

ЕБ-ын түвшинд ихэнх хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хувьд 2023 болон 2024 онуудын суурь болон зорилтот түвшин өөрчлөгдөөгүй хэвээр байна. Суурь түвшнийг тодорхойлохдоо тоон мэдээлэл хуучирсан байдлаар илэрхийлэх тохиолдол байгаа бөгөөд энэ нь үр дүнгийн үзүүлэлтийг бодитоор харьцуулахад бэрхшээл учруулж байна. Тухайлбал, 2024 оны төсвийг боловсруулах явцад 2023 оны жилийн эцсийн тоон мэдээлэл гараагүйгээс 2022 оны тоон мэдээллийг ашиглах, зарим тохиолдолд 2022 оны жилийн эцсийн статистик мэдээлэл гараагүй гэх шалтгаанаар 2021 оны тоон мэдээллийг ашиглах тохиолдол элбэг байгаа юм. Гэхдээ 2024 оны төсвийн хуулийн Хавсралт 1-д тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хувьд суурь түвшнийг 2021, 2022, 2023 онуудын тоо мэдээг ашигласан нь өмнөх жилүүдээс дэвшилттэй байна. ТЕЗ-ийн ЕБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 28-аас харна уу.

## Бага боловсрол

Бага боловсрол зөвхөн 2022 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлттэй байсан бөгөөд суурь түвшинг тодорхойлоогүй тул тухайн үзүүлэлтүүдийг бусад жилүүдтэй харьцуулан дүгнэх болон гүйцэтгэлийг суурь онтой харьцуулах боломжгүй байдалд хүргэж байна. 4 үзүүлэлтээс зөвхөн нэг буюу “дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь” гэсэн үзүүлэлт зорилтот түвшнээсээ давсан бол бусад хүрэх үр дүнгийн үзүүлэлт 86.4-99 хувийн биелэлттэй байсан.

Зураг 7. Бага боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022 он



*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022 он*

### Дунд боловсрол


Дунд боловсролын хувьд 2022 онд 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдсаны зөвхөн 1 үзүүлэлт (гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь) нь зорилтот түвшнээс давж, үлдсэн 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлт 60.7-95.2 хувийн биелэлттэй байсан. 2023 онд 4 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдсан бөгөөд тэдгээрээс зөвхөн 1 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт (чанарын үзүүлэлт болох математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь) зорилтот түвшиндээ хүрээгүй төдийгүй суурь түвшнээсээ ч буурсан байна.

Зураг 8. Дунд боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он

Зураг 9. “Дунд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2022-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он




“Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь” гэсэн үзүүлэлтийн гүйцэтгэл 2022 онд 60 хувь байсан бол 2023 оны төсвийн тухай хуульд суурь үзүүлэлтийг 41.1 хувь, зорилтот түвшнийг 50 хувь гэж тодорхойлсон нь зорилтот түвшнийг бууруулж, хүрэхэд хялбараар тодорхойлсон гэж үзэхээр байна. “Сурах бичгийн хангалтын хувь” гэсэн үр дүнгийн үзүүлэлт 2023 оноос нэмэгдсэн бөгөөд тус үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин 2023, 2024 онд ижилхэн байсан.

### Суурь боловсрол


Суурь боловсролын хувьд 2022 онд 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлт тусгагдсан бөгөөд бүгд зорилтот түвшиндээ хүрч давсан. 2023 онд мөн л 3 үзүүлэлт тусгагдсан ба тэдгээрээс зөвхөн 1 үзүүлэлт (найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь) зорилтот түвшнээс давжээ. Гэхдээ эдгээр үзүүлэлт суурь түвшинтэйгээ харьцуулахад бүгд өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 10. Суурь боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

Зураг 11. “Суурь боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он




Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

Суурь боловсролыг төлөөлөх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хувьд 2022 онд тусгагдаж байсан “Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар” гэсэн үзүүлэлт хасагдсанаас бусдаар харьцангуй тогтвортой байна. “Үдийн цай/хоолны үйлчилгээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо” гэсэн үзүүлэлт 2021, 2023, 2024 онд тусгагдсан боловч 2022 онд уг үзүүлэлт тусгагдаагүй. Гэвч 2022 онд уг үйл ажиллагаанд төсөв батлагдаж, зарцуулагдсан. 2022-2023 онд үдийн цай/хоол хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэл 95.9-99.8 хувь байсан бол үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл нь зорилтот түвшинтэйгээ харьцуулахад 2023 онд 95.3 хувь байсан (2022 онд суурь түвшин тодорхойлогдоогүй тул харьцуулах боломжгүй). Өөрөөр хэлбэл үдийн цай/хоол хөтөлбөрийн хувьд төсвийн болон үр дүнгийн гүйцэтгэлийн зөрүү тийм ч их биш буюу 4.6 пункт байна.

## Бүрэн дунд боловсрол


Бүрэн дунд боловсролтой холбоотой 2022 онд 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлт, 2023 онд 4 үзүүлэлт тусгагдсан. 2022 онд 1 үзүүлэлт (18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь) нь зорилтот түвшиндээ хүрээгүй бол 2023 онд 2 үзүүлэлт (сургалтын чанарыг илэрхийлэх үзүүлэлт болох ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж болон 18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь) зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Гэвч 2023 онд эдгээр үзүүлэлтүүд суурь түвшинтэйгээ харьцуулахад бүгд өссөн. 2022, 2023 онд “Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж” гэсэн үзүүлэлтийг ашиглаж байсан бол 2024 онд “Ерөнхий шалгалтын анхны онооны дундаж” гэсэн үзүүлэлтийг ашиглах болжээ. “Дотуур байранд суралцаж байгаа суралцагчийн тоо”-г 2021 онд үр дүнгийн үзүүлэлт болгон ашиглаж байгаад 2023, 2024 онд хүсэлт гаргасан суралцагчдын тоонд эзлэх хувийг тооцож ашиглах болсон нь дотуур байрны хүртээмжийг илэрхийлэхэд илүү оновчтой болсон байна.

Зураг 12. Бүрэн дунд боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он


Зураг 13. “Бүрэн дунд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшиний өөрчлөлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

“Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн төсөв 2022 онд 1.47 их наяд, 2023 онд 1.44 их наяд төгрөг байсан бөгөөд 2022 онд батлагдсан төсвийн 99.7 хувийг, 2023 онд 99.5 хувийг тус тус зарцуулжээ.

### Зураг 14. “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт



ЕБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн		Сайжруулах шаардлагатай	
	2022 он	2023 он	2022 он	2023 он
Бага боловсрол	Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь		1. Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь 2. Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь 3. Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар	-
Дунд боловсрол	Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	1. Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь 2. Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь 3. Сурах бичгийн хангалтын хувь	1. Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь 2. Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь
Суурь боловсрол	1. Ахлах ангийн (10 дугаар) элсэлтийн хувь 2. Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь 3. Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар	Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	-	1. Ахлах ангийн (10 дугаар) элсэлтийн хувь 2. Үдийн хоолны үйлчилгээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо
Бүрэн, дунд боловсрол	1. Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 2. Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элссэн суралцагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	1. Дотуур байранд суух хүсэлтийн дагуу амьдарч байгаа суралцагчийн хувь 2. Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элссэн суралцагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	1. Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 2. 18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь

Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол


ЕБ хөтөлбөрийн батлагдсан төсөв өндөр, төсвийн гүйцэтгэлийн хувь бараг 100 хувь байсан ч 2022 онд сайжруулах шаардлагатай 6 үзүүлэлт, 2023 онд сайжруулах шаардлагатай 5 үзүүлэлт байна. Тодруулбал, 2022 онд бага боловсролыг төлөөлөх 4 үр дүнгийн үзүүлэлтийн 3-ыг нь сайжруулах шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Үүнд суралцах чадварыг илэрхийлэх 2 үзүүлэлт (унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь), мөн төгсөлтийн хувь гэсэн үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай байсан. Харин эдгээр үзүүлэлтүүдийг 2023 онд тусгаагүй учраас дараагийн жилүүдэд сайжирсан эсэх талаар дүгнэлт гаргах боломжгүй байгаа юм. Дунд боловсролын суралцах чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд зорилтот түвшиндээ хүрээгүй (унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь 2023 онд зорилтот түвшнээс давсныг эс тооцвол) байна. Мөн суралцах чадвартай холбоотой үзүүлэлт болох “ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж” гэсэн үзүүлэлт 2023 онд зорилтот түвшиндээ хүрээгүй. Өөрөөр хэлбэл, 2022, 2023 онд ерөнхий боловсролын түвшинд голдуу суралцах чадвартай холбоотой үзүүлэлтүүд зорилтот түвшиндээ хүрээгүй, сайжруулах шаардлагатай байна.

### *Мэргэжлийн боловсрол, сургалт*

Мэргэжлийн боловсрол, сургалтын түвшинд хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн он оны зорилтот болон хүрсэн түвшин нэлээд ялгаатай байсан. Тухайлбал, “мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүнд амд эзлэх хувь” гэсэн үзүүлэлтийг 2022 онд 2 хувьд хүргэсэн гэж тайлагнасан байтал 2023 онд уг үзүүлэлтийн суурь түвшин 2021 онд 51 хувь байсан төдийгүй 58 хувьд хүрсэн гэжээ. Гэтэл 2024 онд тус үзүүлэлтийн зорилтот түвшнийг 1.9 хувь гэж тодорхойлсон байна. “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь” гэсэн үзүүлэлтийг 2022 онд 80 хувьд хүргэсэн гэж тайлагнасан байтал 2023 онд ердөө 13 барилга, байгууламж, дотуур байранд засвар үйлчилгээ хийсэн гэсэн нь эргэлзээ төрүүлэхээр байгаа юм.

ТЕЗ-ийн МБС хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 29-өөс дэлгэрэнгүй харна уу.

Зураг 15. “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он

Зураг 16. “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшиний өөрчлөлт, 2022-2024 он




Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он

2022 онд МБС-ын салбарт 87.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 81.2 тэрбум төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 92.8 хувь байсан бол 2023 онд 160.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсаны 78.9 буюу 126.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Дараах зурагт МБС-ын салбарын 2022-2023 оны төсөв, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг харуулж байна.



Зураг 17. “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл



Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай
2022 он	<ol style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь</li> <li>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь</li> </ol>	Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь
2023 он	<ol style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь</li> <li>Мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага хангасан орчин бүхий сургалтын байгууллагын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор засвар үйлчилгээ хийсэн барилга, байгууламж, дотуур байрны тоо</li> </ol>	-


Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол

2022-2023 онд “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн батлагдсан төсөв 72.8 тэрбум төгрөгөөр, зарцуулалт нь 45.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн ч төсвийн гүйцэтгэл 13.9 пунктээр буурсан байна. 2022 онд хүрэх дүнгийн 1 үзүүлэлтийн биелэлтийг сайжруулах шаардлагатай байсан. Тодруулбал, мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь гэсэн үзүүлэлтийн биелэлт дөнгөж 76.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан тул сайжруулах шаардлагатай гэсэн ангилалд орууллаа. Уг үзүүлэлт нь техник болон мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны үр дүнг илэрхийлэх ихээхэн чухал үзүүлэлт тул биелэлтийг нь сайжруулахаас гадна зорилтот түвшнийг нь дорвитой ахиулах шаардлагатай байна.

## Дээд боловсрол


ДБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгүүдийг өөр өөрөөр тодорхойлсон, өнгөрсөн хугацаанд хүрсэн үр дүнг дараа нь дахин зорилт болгосон зэрэг нийтлэг дутагдал ажиглагдсанаас гадна сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, тэтгэлэгт хамрагдсан суралцагчдын тоог эс тооцвол үнэн хэрэгтээ их, дээд сургуулийн тооноос өөр үзүүлэлтийг дээд боловсролын түвшинд огт авч үзэхгүй байгаа юм. ТЕЗ-ийн ДБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 30-аас дэлгэрэнгүй харна уу.

Зураг 18. “Дээд боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

Зураг 19. “Дээд боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшиний өөрчлөлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

Энэ нь уг салбарт улсын төсөв зарцуулагдаж байгаа үндсэндээ цорын ганц талбар мөн хэдий ч улс орны хөгжил, өрсөлдөх чадварт хамгийн чухал нөлөөтэй хүний нөөцийн хөгжил, дээд боловсролын салбарт өөр хүрэх үр дүнгийн үзүүлэлт тодорхойлогдохгүй байгаа нь харамсалтай. Цаашдаа ТХЗ-д тусгагдсан хүртээмжтэй, чанартай дээд боловсролтой холбоотой шалгуур үзүүлэлтүүд болох залуус болон насанд хүрэгчдийн оролцооны хувь зэрэг үзүүлэлтийг авч үзэх хэрэгтэй.

2022 онд ДБ-ын салбарт 40.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 58.7 тэрбум төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 143.2 хувь байсан бол 2023 онд 67.1 тэрбум төгрөгийн төсөв батлагдсаны 92.1 хувь буюу 61.8 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Дараах зурагт ДБ-ын салбарын 2022-2023 оны төсөв, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг харуулж байна.

Зураг 20. “Дээд боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл



Дээд боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай	Үр дүндээ хүрээгүй
2022 он	1. Их, дээд сургуулийн тоо 2. Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо 3. Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо (багш, сувилагч)	-	Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо
2023 он	1. Их, дээд сургуулийн тоо 2. Дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо	1. Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо 2. Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо	Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо

Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол


2022-2023 онд ДБ хөтөлбөрийн батлагдсан төсөв 26.1 тэрбум төгрөгөөр, зарцуулалт нь 3.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол төсвийн гүйцэтгэл 51.1 пунктээр буурсан байна. Энэ нь 2022 онд оюутны зээлийн төлөвлөгдөөгүй санхүүжилттэй холбоотойгоор төсвийн гүйцэтгэл 43.2 хувиар хэтэрсэнтэй холбоотой юм. 2022, 2023 онд үр дүндээ хүрээгүй тус бүр 1 үзүүлэлт, сайжруулах шаардлагатай тус бүр 1 ба 3 үзүүлэлт байсан. Тодруулбал, “сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо” гэсэн үзүүлэлт 2022 онд зорилтот түвшиндээ хүрээгүй буюу дөнгөж 47.8 хувийн биелэлттэй байсан бол 2023 онд “дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо” мөн зорилтот түвшиндээ хүрээгүй, 20.6 хувийн биелэлттэй байжээ. Харин “тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын

төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо”, “сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо” гэсэн 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт 81.8-95.6 хувьтай байсан тул сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

### *Насан туршийн боловсрол*


Уг хөтөлбөрийн “дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо” гэсэн үзүүлэлтийн суурь түвшин, бодит түвшин нь өөр хоорондоо нийцэхгүй байсан. Тодруулбал, уг үзүүлэлтийн бодит буюу хүрсэн түвшнийг 2021 онд 5,270 гэж тайлагнасан байтал 2022 онд зорилтот түвшнийг 5,068 буюу өмнөх жилийн гүйцэтгэлээс багаар тогтоосон нь тус үзүүлэлтийн зорилтот түвшнийг тус онд биелүүлэхэд хялбар байдлаар тогтоосон байж болзошгүй гэсэн таамаглалыг төрүүлж байна. Мөн 2022, 2023 онд суурь он нь ижил боловч ялгаатай утга бүхий суурь түвшнийг тодорхойлсон байгаа нь өмнөх жилүүдийн төсөв, тайлантай уялдаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй байдалтай холбоотой юм. Түүнчлэн тус үзүүлэлтийн 2024 оны суурь болон зорилтот түвшнийг ижил тодорхойлсон нь тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болгож байна. ТЕЗ-ийн НТБ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 31-ээс харна уу.

Зураг 21. “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он


Зураг 22. “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он

“Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн хувьд мөн суурь болон зорилтот түвшин уялдаагүй байна. Тус үзүүлэлтийн суурь түвшин 2023 онд 11,344, бодит түвшин нь 15,120 гэж тайлагнасан байтал 2024 онд уг үзүүлэлтийн суурь түвшнийг 9,576, зорилтот түвшнийг мөн адил бууруулж тодорхойлжээ.

Зураг 23. “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт



Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай
2022 он	Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь
2023 он	Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо	Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дүнд боловсрол нөхөн олгох хүний тоо

Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол


2022-2023 онд насан туршийн боловсрол хөтөлбөрийн батлагдсан төсөв 3.0 тэрбум төгрөгөөр, зарцуулалт нь 2.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн ч төсвийн гүйцэтгэл 2 пунктээр буурчээ. 2022 онд тус хөтөлбөрийн “мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь” гэсэн үзүүлэлтийн биелэлт 82.7 хувьтай гарсан нь сайжруулах шаардлагатай үзүүлэлт байна. 2023 онд “дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо” гэсэн үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл 94 хувьтай гарсныг мөн сайжруулах шаардлагатай. Тус үзүүлэлтийн бодит түвшин 2022 онд 5,108 байсан бөгөөд 2023 оны зорилтот түвшнийг 5,430 байхаар тогтоосон хэдий ч 2023 оны хүрсэн түвшин нь 5,095 буюу өмнөх оны гүйцэтгэлээс ч буурчээ. Энэ нь хүрэх үр дүнгийн үзүүлэлт болон батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хооронд бодит хамаарал байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

### **Сургалтын биет орчин**

“Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 4 хүрэх үр дүнгийн үзүүлэлт туссан хэдий ч 2023 онд энэхүү хөтөлбөр байгаагүй. Харин 2024 оны улсын төсөвт зөвхөн “сургалтын нэг компьютерийг ашиглах сурагчдын тоо” хүрэх үр дүнгийн үзүүлэлт туссан байна. Сургалтын биет орчны эдгээр хүрэх үр дүнгийн үзүүлэлт нь боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг хэмжих чухал тоон үзүүлэлтүүд байсан хэдий ч бусад оны улсын төсөвт тусаагүйгээс шалтгаалан төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хэрэгжилт, хүрэх үр дүн хэрхэн ахиц дэвшил үзүүлж буй талаар судлах боломжгүй байна. ТЕЗ-ийн “Сургалтын биет орчин” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2022-2024 оны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 32-оос харна уу.



**Зураг 24. Сургалтын биет орчны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2022-2024 он**



Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2022-2024 он

2024 оны төсвийн тухай хуульд дахин тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлт болох “сургалтын нэг компьютерийг ашиглах сурагчдын тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл 2022 онд 24 байсан тул 2024 оны зорилтот түвшнийг нь 10 гэж тогтоосон байна.

**Зураг 25. Сургалтын биет орчны хөтөлбөрийн 2022 оны хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт**

Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	
	100%-иас дээш гүйцэтгэлтэй	60%-100%-ийн гүйцэтгэлтэй
2022 он	<ol style="list-style-type: none"> <li>Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо</li> <li>Интернетэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь</li> <li>Хүчин чадал ашиглалтын хувь</li> </ol>	Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь


Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол

Сургалтын биет орчны хувьд 2022 оны төсөвт тусгайлсан санхүүжилт тусгагдаагүй бөгөөд хүрэх үр дүнгийн 4 үзүүлэлтээс 3 үзүүлэлт нь үр дүндээ хүрсэн, 1 үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай гэж үзэхээр байна. Сайжруулах шаардлагатай хүрэх үр дүнгийн үзүүлэлт нь боловсролын хүртээмжийг илэрхийлэх үзүүлэлт болох “нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь” бөгөөд 2022 оны зорилтот түвшнийг 41 хувь байхаар төлөвлөсөн ч бодит үр дүн нь 37 хувь байжээ.

### *Тусгай хэрэгцээт боловсрол*

Хэдийгээр тусгай хэрэгцээт боловсролын хүртээмжийг боловсролын бүхий л шатанд үнэлэх хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг 2024 оноос тусгаж эхэлсэн нь сайшаалтай ч тухайн шатны нийт боловсрол эзэмшсэн хүн амд харьцуулан тооцох нь зохимжгүй юм. Тухайлбал, ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6-18 насны ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхдэд харьцуулж тооцох нь хөгжлийн бэрхшээлтэй, сургуулийн насны хүүхдийн тоо нэмэгдэх нь сайн үзүүлэлт мэт ойлгогдохоор байна. Үүний оронд ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг 6-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоонд харьцуулж тооцох нь тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээний хүртээмжийг хэмжихэд илүү тохиромжтой үзүүлэлт юм. ТЕЗ-ийн Тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 33-аас харна уу.


Зураг 26. “Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



*Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, 2021-2024 он*

Мөн он оны улсын төсвийн тухай хуулийн хавсралтад туссан тусгай хэрэгцээт боловсролын хүрэх үр дүнгийн үзүүлэлт өөр хоорондоо уялдаагүй, хэмжих нэгж нь ялгаатай байгаа зэрэг нь тус хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийг өнөөгийн нөхцөлд үнэн зөв үнэлэхэд бэрхшээл үүсгэж байна. Тухайлбал 2021 оны улсын төсөвт тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг “ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо” гэж тодорхойлсон бол 2023 оны улсын төсөвт “сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн, тусгай сургуульд хамран сургалтын хувь” гэсэн шалгуур үзүүлэлтийг авсан. Мөн 2023 онд тухайн үзүүлэлтийн зорилтот түвшин, гүйцэтгэл 2 хувьтай байхад 2024 оны зорилтот түвшинг 0.8 хувь болгож бууруулсан нь уялдаа холбоогүй байна.

Зураг 27. “Тусгай хэрэгцээт боловсрол” хөтөлбөрийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт




Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол

2023 онд тусгай хэрэгцээт боловсрол хөтөлбөрийн батлагдсан төсөв 6.0 тэрбум төгрөг, зарцуулалт нь мөн 6.0 тэрбум төгрөг, төсвийн гүйцэтгэл 100 хувь байсан. Тус хөтөлбөрийн хүрэх дүнгийн үзүүлэлт болох “сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн, тусгай сургуульд хамран сургалтын хувь” нь зорилтот түвшин буюу 2.0 хувьдаа хүрчээ.

### Шинжлэх ухаан, технологи


“Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2021 онд илэрхий зөрүүтэй хэмжигдсэн нь бусад онуудтай харьцуулах боломжгүйд хүргэсэн бөгөөд 2022, 2023 оны хувьд зорилтот түвшнийг 0.18, 0.2 гэж тус тус тодорхойлсон ч тус үзүүлэлтийн бодит хүрсэн түвшин 2023 оны эцэст 0.11 байжээ. Харин 2024 онд тус үзүүлэлтийг тухайн жилийн улсын төсвийн тухай хуульд тусгаагүй. ТЕЗ-ийн ШУТ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн талаар 2021-2024 оны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт хэсэгт харуулсан Хүснэгт 34-өөс харна уу.

Зураг 28. “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт, 2021-2024 он



Эх сурвалж: БШУЯ


Зураг 29. “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдийн зорилтот түвшний өөрчлөлт, 2021-2024 он



Эх сурвалж: БШУЯ

“Судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо” гэсэн хүрэх үр дүнгийн үзүүлэлт 2021, 2022 онд байгаагүй. 2023 онд тус үзүүлэлтийн зорилтот түвшнийг 1,400 гэж тодорхойлсон бөгөөд бодит хүрсэн түвшин нь 1,537 гэж тайлагнасан байхад, 2024 оны суурь үзүүлэлтийг бодит хүрсэн түвшин 1,537-тай дөхүү байдлаар биш, 1,400 гэж тогтоосон нь зорилтот түвшнийг биелэхэд хялбар байхаар сонгон авсныг харуулж байна. Харин “хэвлүүлсэн бүтээлийн тоо” шалгуур үзүүлэлтийн хувьд 2021, 2022 онуудад зорилтот түвшнийг 13 мянга байхаар тогтоосон хэдий ч гүйцэтгэл нь зорилтот түвшиндээ хүрч чадаагүй. Улмаар тус зорилтот түвшнийг 2023 онд 11 мянга болгож бууруулсан нь өмнөх оны гүйцэтгэл 12.5 мянгаас бага байгаа нь тухайн шалгуур үзүүлэлтийг хэрэгжихэд хэт амархан байдлаар тогтоосныг илэрхийлж байна. Мөн “инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцсон ажиллагчид, иргэдийн тоо” шалгуур үзүүлэлт зөвхөн 2023 оны төсөлд тусгагдсан бол “боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо” шалгуур үзүүлэлт 2022 оны төсөлд тусгагдаад, 2023 оноос эхлэн “судалгаа, хөгжүүлэлтийн ажлын тоо” болж өөрчлөгдсөн зэрэг нь тус хөтөлбөрийн үр дүнг харьцуулахад хүндрэл учруулж байна.

Зураг 30. “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн 2022-2023 оны төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт



Шинжлэх ухаан, технологи хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Үр дүндээ хүрсэн	Сайжруулах шаардлагатай	Үр дүндээ хүрээгүй
2022 он	-	1. Хэвлүүлсэн бүтээлийн тоо (дотоод, гадаадад) 2. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо
2023 он	1. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо 2. Хэвлүүлсэн бүтээлийн тоо (дотоод, гадаадад) 3. Инновацын тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцсон ажиллагчид, иргэдийн тоо (6 тэргүүлэх чиглэл, 11 технологийн хүрээнд)	-	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Эх сурвалж: БШУЯ, судлаачдын тооцоолол

2022-2023 онд “Шинжлэх ухаан, технологи” хөтөлбөрийн батлагдсан төсөв 7.2 тэрбум төгрөгөөр, зарцуулалт нь 17.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн ба төсвийн гүйцэтгэл 12.8 пунктээр өсчээ. 2022 онд сайжруулах шаардлагатай 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлт, үр дүндээ хүрээгүй 1 хүрэх үр дүнгийн үзүүлэлт, 2023 онд мөн үр дүндээ хүрээгүй 1 хүрэх үр дүнгийн үзүүлэлт байсан. Тодруулбал “судалгаа хөгжүүлэлтийн ажлын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” гэсэн үзүүлэлт 2022 онд зорилтот түвшиндээ хүрээгүй 61.1 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2023 онд 55 хувь болж буурчээ. Тус үзүүлэлтийн гүйцэтгэл 2023 онд өмнөх оноос буурсан нь зорилтот түвшин өссөн хэдий ч бодит түвшинд ахиц гараагүйгээс шалтгаалсан. Харин 2022 онд “боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо” гэсэн

хүрэх үр дүнгийн үзүүлэлт үр дүндээ хүрээгүй байсан бол уг үзүүлэлт 2023 онд хасагджээ.

## **Хөтөлбөр, зориулалтын төсвийн гүйцэтгэл ба холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт**

### *Дээд боловсрол*

“Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо” гэсэн үзүүлэлтийн биелэлт зорилтот түвшинд хүрээгүйгээс боловсролын зээлийн сангийн төсвийн зарцуулалт нь батлагдсан төсвөөсөө бага байсан юм. Тодруулбал, тус сангийн батлагдсан төсөв 2022 онд 78.3 тэрбум төгрөг байсан бол төсвийн гүйцэтгэл нь 58.5 тэрбум төгрөг буюу 74.7 хувьтай байжээ. Мөн оюутны хөгжлийн зээлд зориулсан төсөв 2022 онд 21.8 тэрбум төгрөг байхаар батлагдсан ч гүйцэтгэл нь 14.2 тэрбум (65.1 хувь) байсан. Энэ нь 2022-2023 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллежийн тоо буурч, улмаар суралцагчдын тоо багассантай холбоотой юм. Боловсролын яамны мэдээгээр 2021 онд 88 их, дээд сургууль, коллеж байсан бол 2022 онд 69 болж буурсан бөгөөд суралцагчдын тоо мөн хугацаанд 149 мянга орчмоос 145 мянга болж багассан.

“Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо” гэсэн үзүүлэлтийн биелэлт мөн л зорилтот түвшинд хүрээгүй тул төсвийн гүйцэтгэл нь бага байсан. Тухайлбал, 2022 онд гадаадад суралцагсдын зээлд 18.7 тэрбум төгрөг төсөвлөсөн ч дөнгөж 8.9 тэрбум төгрөг буюу 47.6 хувийг нь зарцуулжээ. Энэ нь 2022 онд Засгийн газрын “Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, тэтгэлгийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 346 дугаар тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам” шинэчлэгдэн батлагдаж, дэлхийн шилдэг 50 сургуульд үндсэн хөтөлбөрөөр суралцах эрх авсан (өмнө нь шилдэг 100 сургууль байсан), 50 ба түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан суралцагчид хамрагдах боломжтой болсон (өмнө нь тэтгэлэг авсан байх шаардлага байгаагүй)-той холбоотой. Улмаар 2023 онд тус зориулалтаар 10 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан байна. Дээрх гадаадад суралцагсдын



зээлээс гадна Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгээр мөн дэлхийн шилдэг сургуульд суралцах боломжтой бөгөөд эдгээр тэтгэлгийн төсөв жилээс жилд нэмэгдэж байгаа юм.

### *Бүлгийн дүгнэлт*

Энэ бүлэгт БШУС-ын төсвийн гүйцэтгэлийн тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг хэрхэн үнэлснийг авч үзэж, холбогдох дүн шинжилгээг хийлээ. Дүн шинжилгээнээс дараах нийтлэг зүйлс ажиглагдлаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийг хэдийгээр хөтөлбөрөөр тайлагнасан боловч арга хэмжээ бүрээр гарахгүй тул хөтөлбөрийн зарим хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар дүн шинжилгээ хийх боломжгүй байна. Тухайлбал, “5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь” гэсэн үзүүлэлтийг сайжруулахын тулд чухам ямар арга хэмжээ авсан, түүнд ямар төсөв хуваарилагдаж, зарцуулсныг иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнэх боломжгүй байгаа юм.
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн суурь түвшнийг тодорхойлоогүй байснаас гадна жил, жилийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо зохих суурь түвшин, тухайн үзүүлэлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл, чиг хандлага зэргийг төдийлөн ашигладаггүй нийтлэг дутагдал байна.
- Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тус бүр 1-2 удаа өөрчлөлт оруулж, төсвийг тодотгон ТЕЗ нарын төсвийн хуваарилалт өөрчлөгдсөн байтал хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдэд ямар ч өөрчлөлт ороогүй.

- “Мэргэжлийн боловсрол” зэрэг хөтөлбөрийн зорилтот түвшнийг хүрсэн үр дүнд харьцуулахад хэт өндөр хувиар давуулан биелүүлсэн байгаа нь анх төлөвлөхдөө жилийн дунджаас доогуур буюу хүчин чармайлт гаргахгүйгээр хялбар биелэгдэх зорилтот түвшнийг сонгосон байж болзошгүй байна.
- Тухайн хөтөлбөр, арга хэмжээнд төсөвлөсөн төсөв, түүний гүйцэтгэл холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, биелэлттэй төдийлөн хамааралгүй байх хандлага ажиглагдсан. Тухайлбал, 2023 онд мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн батлагдсан төсөв 160.3 тэрбум төгрөг, зарцуулалт нь 126.4 тэрбум төгрөг байсан буюу төсвийн гүйцэтгэл 78.9 хувьтай байсан ч хөтөлбөрийн 2 хүрэх дүнгийн үзүүлэлтийн биелэлт 100 хувиас илүү байжээ. Энэ нь нэг бол тухайн хөтөлбөрийн төсвийг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн баталсан, нөгөө бол хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн зорилтот түвшнийг хялбар биелэгдэхээр тодорхойлсон гэж дүгнэх үндэстэй юм.

## **5. БШУЯ-НЫ 2022-2023 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ДУРДСАН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГА ҮНЭЛЖ ДҮГНЭСЭН БАЙДАЛ**

НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр БШУЯ 2022 оны төсвийн зарлага, үр дүнгийн гүйцэтгэлийн тайлангаа боловсруулсан. Энэхүү тайланд тус яамны захиран зарцуулж, хэрэгжүүлдэг “Сургуулийн өмнөх боловсрол”, “Ерөнхий боловсрол”, “Насан туршийн боловсрол”, “Тусгай хэрэгцээт боловсрол”, “Мэргэжлийн боловсрол”, “Дээд боловсрол”, “Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага”, “Боловсрол, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ” гэсэн хөтөлбөрүүдийн төсвийн зарлага, үр дүнг тайлагнасан бөгөөд “Шинжлэх ухаан, технологи” гэх хөтөлбөрийн төсвийн зарлага болон үр дүнгийн гүйцэтгэлийг авч үзээгүй. 2022 онд сургуулийн өмнөх боловсролын 2, ерөнхий боловсролын 17, насан туршийн боловсролын 2, дээд боловсролын 4, мэргэжлийн боловсролын 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлт батлагдсан бөгөөд тэдгээрийн 2022 оны зорилтот түвшний биелэлтийг дахин тооцоолж, ерөнхий биелэлт нь 99.5 хувь байсан гэж тус тайланд дүгнэжээ. Боловсролын түвшин тус бүрээр хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн биелэлтийг БШУЯ хэрхэн тайлагнасан болон судлаачийн<sup>1</sup> дахин тооцоолсон үр дүнтэй дараах хэсгүүдэд харьцууллаа.

---

<sup>1</sup> НҮБХХ-ийн зөвлөх А.Заяадэлгэр нар

## Сургуулийн өмнөх боловсрол

СӨБ-ын түвшинд хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд үр дүнгийн хоёр үзүүлэлт батлагдсан. БШУЯ болон НҮБХХ-ийн судлаачийн тайлагнасан “СӨБ-ын хамран сургалтын хувь” гэх үзүүлэлтийн хүрсэн түвшин ижил байсан бол “сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь” гэсэн үзүүлэлтийн 2022 онд хүрсэн түвшин БШУЯ-ны мэдээлснээр 93 хувь байсан бол судлаач 86.7 хувь хэмээн тооцсон байна. Өөрөөр хэлбэл 2 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн 1 үзүүлэлтийн хүрсэн түвшин зөрүүтэй байсан гэсэн үг.

## Ерөнхий боловсрол

БШУЯ-ны тайлагнасан болон судлаачийн дахин тооцоолсон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн бодит буюу хүрсэн түвшин бага зэрэг ялгаатай байгааг дараах хүснэгтээр харуулж байна.

*Хүснэгт 23. Ерөнхий боловсролын хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он*

Үр дүнгийн үзүүлэлт	БШУЯ-ны тайлагнасан нь	Судлаачийн дахин тооцоолсон нь	Зөрүү
Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	57	54.1	-2.9
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	57	54.4	-2.6
Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь	99	99	0
Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар	97	96.8	-0.2
Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	60	58.8	-1.2
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	34	32	-2

Үр дүнгийн үзүүлэлт	БШУЯ-ны тайлагнасан нь	Судлаачийн дахин тооцоолсон нь	Зөрүү
Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	99	99.4	+0.4
Ахлах ангийн (10 дугаар) элсэлтийн хувь	84	82.2	-1.8
Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	96	95.7	-0.3
Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар	98	98.5	+0.5
Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	512	513	+1
Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элссэн суралцагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	99	98	-1
18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	78	78	0

*Эх сурвалж: БШУЯ, НҮБХХ*

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт 13 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн 8 үзүүлэлтийг БШУЯ хэтрүүлэн үнэлсэн бол 3 үзүүлэлтийн биелэлтийг доогуур тооцжээ. Харин 2 үзүүлэлтийн биелэлт зөрүүгүй байна. Гэхдээ судлаачийн дахин тооцоолсон биелэлт болон БШУЯ-ны тайлагнасан биелэлтийн зөрүү бага буюу ихдээ 3 пунктээс хэтрэхгүй байгаа юм.

## Сургалтын биет орчин

Сургалтын биет орчныг сайжруулахтай холбоотой хүрэх үр дүнгийн 4 үзүүлэлтийн БШУЯ-ны тайлагнасан болон судлаачийн дахин тооцоолсон бодит буюу хүрсэн түвшнийг дараах хүснэгтээр харуулж байна.

*Хүснэгт 24. “Сургалтын биет орчин” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он*

Үр дүнгийн үзүүлэлт	БШУЯ-ны тайлагнасан нь	Судлаачийн дахин тооцоолсон нь	Зөрүү
Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчийн тоо	24	25	+1
Интернэтэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь	71	67	-4
Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	37	36	-1
Хүчин чадал ашиглалтын хувь	141	157	+16

*Эх сурвалж: БШУЯ, НҮБХХ*

Хүрэх үр дүнгийн 4 үзүүлэлт бүгд зөрүүтэй тооцогдсоноос “Хүчин чадал ашиглалтын хувь” гэсэн үзүүлэлтийн биелэлтийг судлаач нэлээд өөр тооцоолсон байна. Тухайлбал БШУЯ хүчин чадал ашиглалтын хувийг харьцангуй бага байсан гэж тайлагнажээ.

## Мэргэжлийн боловсрол

МБС-ын түвшинд батлагдсан хүрэх үр дүнгийн 3 үзүүлэлтийн хувьд БШУЯ-ны тайлагнасан болон судлаачийн дахин тооцоолсон биелэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав.

*Хүснэгт 25. “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он*

Үр дүнгийн үзүүлэлт	БШУЯ-ны тайлагнасан нь	Судлаачийн дахин тооцоолсон нь	Зөрүү
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь	2	1.75	-0.25
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	52	58.8	+6.8
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь	80	80	0

*Эх сурвалж: БШУЯ, НҮБХХ*

Энд 3 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн 2 үзүүлэлтийн биелэлт зөрүүтэй тооцогдсон бөгөөд “мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь”-ийг БШУЯ 52 хувь гэж тайлагнасан бол судлаачийн дахин тооцооллоор 58.8 хувь буюу 6.8 пунктээр нэмэгджээ.

## Дээд боловсрол

ДБ-ын түвшинд батлагдсан хүрэх үр дүнгийн 4 үзүүлэлтийн хувьд БШУЯ-ны тайлагнасан болон судлаачийн дахин тооцоолсон биелэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн харуулав. Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт огт зөрөөгүй байсан.

Хүснэгт 26. “Дээд боловсрол” хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийн хүрсэн түвшин, 2022 он

Үр дүнгийн үзүүлэлт	БШУЯ-ны тайлагнасан нь	Судлаачийн дахин тооцоолсон нь	Зөрүү
Их, дээд сургуулийн тоо	69	69	0
Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	508	508	0
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо (багш, сувилагч)	5,824	5,824	0
Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан суралцагчийн тоо	7,168	7,168	0

Эх сурвалж: БШУЯ, НҮБХХ

## Насан туршийн боловсрол

“Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хувьд хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд үр дүнгийн 2 үзүүлэлт батлагдсан. БШУЯ-ны тайлагнасан “дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо” гэх үзүүлэлтийн хүрсэн түвшин 5,108 байсан бол НҮБХХ-ийн судлаач 5,103 гэж тооцоолжээ. Харин “мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь” гэсэн үзүүлэлтийн хүрсэн түвшнийг БШУЯ тайлагнаагүй бол судлаач 12.4 хувь хэмээн тооцоолсон байна.

Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас 2021 онд “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийсэн байдаг. Тайланд хамран сургалт нэмэгдэж



байгаа хэдий ч төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн тоо хүчин чадлаас 2 дахин хэтэрсэн, сургалтын чанарыг үнэлж дүгнэх боломж бүрдээгүй байсныг онцлоод төсвийн төлөвлөлт бодитой бус, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсвөө хэмнэх боломжийг алдсан гэж дүгнэжээ. Энэ нь хэдийгээр тухайн салбарт ногдох төсвийн гүйцэтгэл өндөр байгаа ч хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдэд төдийлөн дорвитой ахиц гарахгүй байгаагийн шалтгаан байж болох юм.

Мөн онд УАГ-аас “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийсэн бөгөөд хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлээгүй байсныг онцолж, төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналт сул байна гэж дүгнэсэн. Тайланд ЕБС-ийн бүлэг дүүргэлт хэтэрсэн байгаа талаар ноцтойгоор авч үзсэн байхад ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд бүлэг дүүргэлт, багш-сурагчийн харьцаа гэх зэрэг үзүүлэлт огт тусгагдахгүй байгаа нь зүй ёсоор анхаарал татаж байна.

УАГ-ын 2023 онд хийсэн “Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дээд боловсролын сургалт, судалгаанд зориулсан улсын төсвийн дэмжлэг бага байгаагаас салбарын бодлого, хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгааг дурджээ. Энэ нь ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд салбарын гүйцэтгэлийг илэрхийлэхүйц өргөн агуулга, хүрээний үзүүлэлтүүд биш байгааг нотолж байгаа юм.

2023 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан “Монгол Улсын Үндэсний сайн дурын хоёрдугаарилтгэл 2023: ТХЗ-ын хэрэгжилт” тайланд чанартай боловсролыг дэмжих зорилгын зарим үзүүлэлтийн хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн хандлага буурсан гэж дүгнэсэн байна. Тухайлбал, бага насны хүүхдийн хөгжлийн индекс төдийлөн сайжраагүй, мэргэжлийн болон дээд боловсролын тогтолцоо сул, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх хэрэгцээ хэвээр, боловсролын зохих түвшинд багшлах шаардлагыг хангасан мэргэжлийн багш нарын хувийн жинтэй буурсан байдалтай

байгааг онцолжээ. Гэхдээ суурь дэд бүтцээр хангагдсан сургууль, цэцэрлэгүүд нэмэгдэж, сурагчдын суралцах орчин сайжирч байгаа, хүн амын бичиг үсэг тайлагдалтын хүйсийн ялгаа багасаж байгаа зэрэг эерэг өөрчлөлтүүд мөн гарсан. Дээрх байдалд “Ковид-19” цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөө их байсныг тайланд дурдаад бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг урт хугацаагаар зогсоож, теле болон цахим хэлбэрээр зайнаас сургалт явуулсан нь сургалтын хүртээмж, тэгш байдлыг бууруулсан төдийгүй боловсролын чанар муудаж, суралцагчдын дийлэнх нь хичээлийн агуулгыг бүрэн эзэмшиж чадаагүй, хичээлээс хоцрогдсон гэжээ. Өөрөөр хэлбэл боловсролын салбарын батлагдсан төсөв, зарцуулалт нэмэгдэж, төсвийн гүйцэтгэлийн хувь өсөөд байгаа ч салбарын гүйцэтгэлийн үндсэн үр дүнгүүдэд дорвитой ахиц бас төдийлөн гарахгүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

ННФ-ын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамын хийсэн “Монгол Улс: Төсвийн гүйцэтгэл ба ТХЗ-ууд” шинжилгээнд манай улсын 7 салбарын төсвийн гүйцэтгэлийн чиг хандлагыг үндэсний түвшин дэх ТХЗ-ын хэрэгжилтийн явцтай холбон авч үзсэн. Судалгаанаас харахад Монгол Улсын төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс доогуур байгаатай адил салбарын түвшинд ч төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн зөрүү нь өндөр хэвээр байжээ. НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгоос 10-ыг нь хамарч буй 7 салбарын 3 жил (2018, 2019, 2020 он)-ийн эцсийн бодит зарцуулалт нь батлагдсан төсөвтөө хүрээгүйг тайланд онцолсон. 2021 оны ТХЗ-ын индексээр зөвхөн ТХЗ-4 буюу “чанартай боловсролыг дэмжих” зорилго биелсэн хэдий ч тус салбарт сүүлийн жилүүдэд “Ковид-19 цар тахлын хорио, түүний боловсролын салбарт үзүүлсэн сөрөг нөлөөг даван туулах хангалттай санхүүжилт байгаагүй төдийгүй боловсролын салбарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү -11.8 хувь байжээ. Улсын төсвийн зарлагад боловсролын салбар хамгийн өндөр хувийг эзэлдэг ч “боловсрол олгох”-оос “чанартай боловсрол олгох” зорилгод шилжихэд бэрхшээлтэй хэвээр байгаа тул тус салбарын төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүүг бууруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна. Энэ нь төсвийн гүйцэтгэл болон системийн

гүйцэтгэлийг илэрхийлдэг хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтийн уялдаа холбоог сайжруулах хэрэгтэйг нотолж байгаа юм.

## Бүлгийн дүгнэлт

Энэ бүлэгт НҮБХХ-өөс гаргасан судалгаа, тайлан, ҮАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, болон бусад холбогдох судалгаануудыг авч үзсэн бөгөөд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- БШУЯ дангаараа тайлагнасан болон НҮБХХ-тэй хамтран боловсруулсан тайланд зарим хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлт зөрүүтэй байсан. Тухайлбал, “сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь” гэсэн үзүүлэлтийн 2022 онд хүрсэн түвшин БШУЯ-ны мэдээлснээр 93 хувь байсан бол судлаач 86.7 хувь хэмээн тооцсон байна. ЕБС-ийн нийт 13 хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн 8 үзүүлэлтийг БШУЯ хэтрүүлэн үнэлсэн бол 3 үзүүлэлтийн биелэлтийг доогуур тооцжээ. МБ-ын хүрэх үр дүнгийн 4 үзүүлэлт бүгд зөрүүтэй тооцогдсон.
- ҮАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудад хамран сургалт нэмэгдэж байгаа хэдий ч төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн тоо хүчин чадлаас 2 дахин хэтэрсэн, сургалтын чанарыг үнэлж дүгнэх боломж бүрдээгүй байсныг онцлоод төсвийн төлөвлөлт бодитой бус, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсвөө хэмнэх боломжийг алдсан гэж дүгнэжээ.
- Ерөнхий боловсролын хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлээгүй байсныг онцолж, төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналт сул байна гэж дүгнэсэн. Тайланд ЕБС-ийн бүлэг дүүргэлт хэтэрсэн байгаа талаар анхааруулсан байхад БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд бүлэг дүүргэлт, багш-сурагчийн харьцаа зэрэг үзүүлэлт огт тусгагдахгүй байна.
- ҮАГ-ын 2023 онд хийсэн “Дээд боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд дээд

боловсролын сургалт, судалгаанд зориулсан улсын төсвийн дэмжлэг бага байгаагаас салбарын бодлого, хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгааг дурджээ. Энэ нь БШУС-ын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд салбарын гүйцэтгэлийг илэрхийлэхүйц өргөн агуулга, хүрээний үзүүлэлтүүд биш байгааг нотолж байгаа юм.

- 2023 онд Засгийн газар НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулсан “Монгол Улсын Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэл 2023: ТХЗ-ын хэрэгжилт” тайланд чанартай боловсролыг дэмжих зорилгын зарим үзүүлэлтийн хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэлийн хандлага буурсан гэж дүгнэсэн. Тайланд үндэслэн боловсролын салбарын батлагдсан төсөв, зарцуулалт нэмэгдэж төсвийн гүйцэтгэлийн хувь өсөж байгаа ч салбарын гүйцэтгэлийн үндсэн үр дүнгүүдэд дорвитой ахиц бас төдийлөн гарахгүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### Дүгнэлт

БШУС-ын 2022, 2023 оны төсвийн хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд, тэдгээрийг ТХЗ болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдтэй харьцуулсан байдал, төсвийн гүйцэтгэлийн тайланд дурдсан гүйцэтгэлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ихэнхдээ тогтвортой биш байна. Түүнчлэн томъёолол нь өөрчлөгдөх тохиолдлууд байна. Жишээлбэл, “5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь” гэсэн үзүүлэлт “сургуульд элсэхийн өмнөх 1 жилд зохион байгуулалттай сургалтад хамрагдах хувь” гэсэн үзүүлэлттэй агуулгын хувьд ижил ч өөр үзүүлэлт мэтээр томъёологджээ.
- 2021 онтой харьцуулахад 2022, 2023 онд хүрэх үр дүнгийн үзүүлэлтээр илүүтэй гарцын буюу үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд тодорхойлсон нь тун сайшаалтай хэрэг юм. Энэ нь сүүлийн үед төсөв, бодлогын уялдааг сайжруулж, үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг дэмжиж байгаатай холбоотой гэж үзэхээр байна. Жишээ татахад 2021 онд ЕБС-ийн тоо, төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн суралцагсдын тоо гэх зэрэг орцын үзүүлэлтүүдийг авч үздэг байсан тул 2022, 2023 онд хамран сургалтын хувь, сургалтын чанар зэрэг боловсролын хүртээмж

төдийгүй чанартай холбоотой хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг тусгах болжээ.

- Хэдий тийм ч ТХЗ-4, “Алсын хараа-2050”, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” зэрэг бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүлэг дүүргэлт, хөдөлмөр эрхлэлт, жендэр, эрх тэгш байдлыг илэрхийлсэн чухал хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд дунд тусгалаа олохгүй байгаад анхаарч, улсын төсвийн хөрөнгийг зарцуулснаар хүрэх үр дүнг эрх тэгш байдлыг хангасан, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимтай нийцүүлэн, илүү оновчтой тодорхойлох шаардлагатай байна. Жишээлбэл, “Ерөнхий боловсрол” хөтөлбөрт бүлэг дүүргэлттэй холбоотой хүрэх үр дүнгийн үзүүлэлт огт байхгүй байгаа юм. Гэтэл сүүлийн жилүүдэд нийслэл хотын зарим сургуулийн 1 дүгээр анги 50-60 хүүхэдтэй байх тохиолдол нийтлэг байна.
- Төсвийн гүйцэтгэлийг хэдийгээр хөтөлбөрөөр тайлагнасан боловч арга хэмжээ бүрээр гарахгүй тул хөтөлбөрийн зарим хүрэх үр дүн болон төсөв хоорондын уялдааны талаар дүн шинжилгээ хийх боломжгүй байв. Тухайлбал, “5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь” гэсэн үзүүлэлтийг сайжруулахын тулд чухам ямар арга хэмжээ авсан, түүнд ямар төсөв хуваарилагдаж, зарцуулсныг иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнэх боломжгүй байгаа юм.
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн Хавсралт 1-д хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн суурь түвшнийг тодорхойлоогүй байснаас гадна жил жилийн зорилтот түвшнийг тодорхойлохдоо зохих суурь түвшин, тухайн үзүүлэлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл, чиг хандлага зэргийг төдийлөн ашигладаггүй нийтлэг дутагдал байна.
- Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тус бүр 1-2 удаа өөрчлөлт оруулж, төсвийг тодотгон ТЕЗ нарын төсвийн хуваарилалт өөрчлөгдсөн байтал хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон

хэмжээний үзүүлэлтүүдэд ямар ч өөрчлөлт ороогүй.

- “Мэргэжлийн боловсрол” зэрэг хөтөлбөрийн зорилтот түвшнийг хүрсэн үр дүнд харьцуулахад хэт өндөр хувиар давуулан биелүүлсэн байгаа нь анх төлөвлөхдөө жилийн дунджаас доогуур буюу хүчин чармайлт гаргахгүйгээр хялбар биелэгдэх зорилтот түвшнийг сонгосон байж болзошгүй байна.
- Тухайн хөтөлбөр, арга хэмжээнд төсөвлөсөн төсөв, түүний гүйцэтгэл холбогдох хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, биелэлттэй төдийлөн хамааралгүй байх хандлага ажиглагдсан. Тухайлбал, 2023 онд “Мэргэжлийн боловсрол” хөтөлбөрийн батлагдсан төсөв 160.3 тэрбум төгрөг, зарцуулалт нь 126.4 тэрбум төгрөг байсан буюу төсвийн гүйцэтгэл 78.9 хувьтай байсан ч хөтөлбөрийн 2 хүрэх дүнгийн үзүүлэлтийн биелэлт 100 хувиас илүү байжээ. Энэ нь нэг бол тухайн хөтөлбөрийн төсвийг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн баталсан, нөгөө бол хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн зорилтот түвшнийг хялбар биелэгдэхээр тодорхойлсон гэж дүгнэх үндэстэй юм.
- Хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн биелэлтээс харахад “5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь” гэх мэт хүртээмжтэй холбоотой үзүүлэлтүүд, ерөнхий боловсролын хувьд ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж зэрэг суралцах чадварын үнэлгээтэй холбоотой үзүүлэлтүүд, мэргэжлийн боловсролын сургалтанд хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь гэх зэрэг үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг илүүтэй сайжруулах шаардлагатай байна.
- Зарим хүрэх үр дүнгийн биелэлтийг БШУЯ өөрөө болон бусад байгууллагатай хамтран гаргасан тайланд зөрүүтэй тайлагнасан байгаагаас харахад хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлох, суурь түвшин, хүрэх үр дүнг бодитой тодорхойлсон эсэх, тоон мэдээллийн найдвартай байдлыг нягтлах хэрэгцээ үүсэж болзошгүй байна.

## Зөвлөмж

Энэхүү судалгааны хүрээнд БШУС-ын хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд тэдгээрийн ТХЗ болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгүүдийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдтэй нийцтэй байдал, тогтвортой байдалд үнэлэлт дүгнэлт хийж, хөтөлбөр бүрээр батлагдсан төсөв, гүйцэтгэл, хүрэх үр дүнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийсэн үр дүн, дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

*Хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлох чиглэлээр:*

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг аль болох оновчтой байдлаар буюу тухайн салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийг илэрхийлэх, үр дүнгийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бусад баримт бичгүүд болон ТХЗ зэрэг олон улсын жишигтэй нийцтэй байхаар тодорхойлох;
- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо жендэр, нийгмийн бүлэг зэргээр ангилсан зорилтот түвшнийг тодорхойлж, эрх тэгш байдал, хэнийг ч орхигдуулахгүй зарчмыг баримтлах;
- ТЕЗ-ийн хүрэх үр дүнгүүдийн үзүүлэлтүүдийг зөвхөн боловсролын хүртээмж биш чанартай боловсрол олгох чиглэлээр тодорхойлох;
- Хүрэх үр дүнгийн суурь түвшин, зорилтот түвшин, биелэлт зэргийг аль болох бодитой, боломжит тоон мэдээлэлд үндэслэж, бусад бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн холбогдох түвшинтэй уялдуулан тодорхойлж, тооцох;
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийг аль болох тогтвортой байлгаж, өөр хугацаанд харьцуулж дүгнэх боломжоор хангах;
- Төсөвт хэд хэдэн удаа тодотгол хийсэн байтал үр дүнгийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт ороогүй, ТЕЗ нар төсвийн саналаа хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүдийн хамт Сангийн яаманд хүргүүлсэн хувилбарт тусгагдсан төсөв өөрчлөгдсөн атал үр дүнгийн үзүүлэлтийн санал өөрчлөлт оролгүй батлагдах тохиолдол



түгээмэл байгаад анхаарч, цаашид төсөвт тодотгол хийх, эсхүл төсвийн саналд өөрчлөлт орох тохиолдолд үр дүнгийн үзүүлэлтүүдэд холбогдох бодит өөрчлөлтийг тусгадаг байх.

*Хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, тайлагналын чиглэлээр:*

- Хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн гүйцэтгэл, биелэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, учир шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг тайлбарладаг байх;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой мэдээллийг олон нийтэд илүү нээлттэй болгож, салбарын байгууллагууд, мэргэжлийн хүмүүстэй нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар дараа жилийн төсвийн төлөвлөлтийг бодитой, үр дүнд чиглэсэн, бодлогын зорилготой уялдаатай болгох;
- Цаашид 5 настай хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт, ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж зэрэг суралцагчдын суралцах чадварын үзүүлэлтүүд, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт гэх зэрэг гүйцэтгэлийг нь сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдэд илүүтэй анхаарал хандуулж, төсвөө оновчтой хуваарилах тал дээр анхаарах.

## НОМ ЗҮЙ

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө  
2021-2030

НҮБХХ (2022). Төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайлагналын  
өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ. Улаанбаатар.

НҮБХХ (2023). Боловсролын салбарын 2022 оны төсвийн зарлага  
болон үр дүнгийн гүйцэтгэлийн тайлан. Улаанбаатар.

А.Заяадэлгэр & С.Эрдэмчимэг (2020). Боловсролын төсвийн  
зарлагын шинжилгээ: Хандлага (2012-2019) болон өнөөгийн байдал  
(2019). НҮБХХ, Улаанбаатар, Монгол Улс.

Монгол Улсын Засгийн газар (2023). Монгол Улсын Үндэсний  
сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт.  
Улаанбаатар хот

ҮАГ (2023). Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын  
хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. Улаанбаатар.

ҮАГ (2023). Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын

хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан. Улаанбаатар.

Олон улсын төсвийн түншлэл (2023). Д.Оюунбадам, “Монгол Улс: Төсвийн гүйцэтгэл ба ТХЗ-ууд” судалгаа

ҮСХ (2021). Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч салбарын танилцуулга

ҮСХ (2022). Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмч салбарын танилцуулга

ҮСХ, БШУЯ, Боловсролын салбарын статистик мэдээлэл 2021-2022

ҮСХ, БШУЯ, Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл 2022-2023

## ХАВСРАЛТУУД

Хүснэгт 27. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Сургуулийн өмнөх боловсролын түвшин, 2021-2024 он

Үзүүлэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин*	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин
Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь	62.6 (хамран сургалтын бохир жин)	-	74	90	62.5 (2021)	88.5	89.7	77.8 (2021)	87		
5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалтын хувь	-	-	86	93	91.3 (2021)	96.7	94.8	93 (2021)	100		
5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж гүйцэтгэлийн хувь	-	-	-	-	60.7 (2021)	65	65	60.7 (2021)	73		

\* суурь түвшинийг тодорхойлоогүй.

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 28. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Ерөнхий боловсролын түвшин, 2021-2024 он

Үзүүлэлт	2021 он		2022 он		2023 он		2024 он			
	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин (2021 он)	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин
Бага боловсрол:										
Унших суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	-	-		60	57	-	-	-	-	-
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 5 дугаар ангийн суралцагчдын хувь	-	-		66	57	-	-	-	-	-
Дөрвөн хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас бага боловсрол эзэмшсэн хувь	-	-		98	99	-	-	-	-	-
Төгсөлтийн хувь, 11 настай хүн амаар	-	-		98	97	-	-	-	-	-
Дунд боловсрол:										
Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	-	-		63	60	41.1	50	59.8	41.1 (2021 он)	50

Үзүүдэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин (2021 он)	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Суурь түвшин
Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн сурагчдагчдын гүйцэтгэлийн дундаж хувь	-	-		56	34	33.7	41	33.6	33.7 (2021 он)	41	41
Гурван хичээлийн жилийн өмнө 6 дугаар ангид элссэн сурагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	-	-		98	99	98.4	99.2	99.9	98.4 (2021 он)	99.2	99.2
Сурах бичгийн хангалтын хувь	-	-	-	-	-	56	63	63	56 (2022 он)	63	63
<b>Суурь боловсрол:</b>											
Ахлах ангийн (10 дугаар) элсэлтийн хувь	-	-	-	82	84	84.2	92	90.1	84.2 (2022 он)	92	92
Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн сурагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь	-	-		96	96	94.8	96	103.3	94.8 (2022 он)	96	96

Үзүүлэлт	2021 он		2022 он		2023 он		2024 он			
	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин (2021 он)	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин
Төгсөлтийн хувь, 15 настай хүн амаар	-	-		98	-	-	-	-	-	-
<b>Бүрэн дунд боловсрол:</b>										
Үдийн цай/хоолны үйлчилгээнд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо	368195	371480	-	-	-	371480	401200	382161	382000 (2022 он)	401000
Ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж	-	-	-	511	512	500	518	508.6	-	-
Ерөнхий шалгалтын анхны онооны дундаж	-	-	-	-	-	-	-	-	48.05 (2022 он)	50
Хоёр хичээлийн жилийн өмнө 10 дугаар ангид элсэн сурагчдаас бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	-	-	-	96	99	96.4	98	101.4	96.4 (2022 он)	98
18 настай хүн амд эзлэх бүрэн дунд боловсрол эзэмшсэн хувь	-	-	-	79	78	77.1	82	81	77.1 (2022 он)	82

Үзүүдэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин (2021 он)	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Зорилтот түвшин
Дотгуур байранд суух хүсэлтийн дагуу амьдарч байгаа суралцагчийн хувь	-	-	-	-	-	69.3	75	97	92	92.5	92.5
Дотгуур байранд хамрагдах хүүхдийн тоо	40370	32576	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад: (2021 болон 2024 оны Төсвийн тухай хуульд бага, дунд, суурь боловсрол гэх мэтээр ангилаагүй ба дээр дурдсан ангиллуудад хамруулаагүйг энд оруулав )											
Суралцах хүүхдийн тоо	717142	717451	-	-	-	-	-	-	-	-	-
ЕБС-ийн тоо	870	848	-	-	-	-	-	-	-	-	-
Хамран сургалтын хувь	93	Бага боловсролын хамран сургалтын бохир жин -97.0 Дунд ангийн хамран сургалтын бохир жин -96.3	-	-	-	-	-	-	-	-	-
Төрийн бус өмчийн сургуулийн тоо	165	166	-	-	-	-	-	-	-	-	-



Үзүүлэлт	2021 он		2022 он		2023 он		2024 он			
	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин (2021 он)	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин
Төрийн бус өмчийн сургуульд хамрагдах хүүхдийн тоо	56513	53754	-	-	-	-	-	-	-	-
ЕБ-ын тусгай хэрэгцээг сургуульд хамрагдах хүүхдийн тоо	6251	5606	-	-	-	-	-	-	-	-
Нэг компьютерг ногдох хүүхэд	-	-	-	-	-	-	-	-	24 (2023 он)	10
Цахим плагформоор дамжуулж явуулдаг хичээл	-	-	-	-	-	-	-	-	2 (2023 он)	3
Цахим сургалтад хамрагдах ерөнхий боловсролын суралцагч	-	-	-	-	-	-	-	-	10439 (2023 он)	22000

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 29. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Мэргэжлийн боловсрол, сургалтын түвшин, 2021-2024 он

Үзүүлэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан суралцагчийн тухайн насны хүн амд эзлэх хувь		-	1.87	2	51 (2021)	58	1.87 (2021)	58	58	1.87 (2021)	1.9
Мэргэжлийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага хангасан орчин бүхий сургалтын байгууллагын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор засвар үйлчилгээ хийсэн барилга, байгууламж, дотуур байрны тоо	7	-	-	-	4 (2021)	13	-	13	13	-	-
Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	51.7	-	68	52	-	-	-	-	-	51.6 (2021)	53
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчныг стандартад нийцүүлэх хувь		-	10	80	-	-	-	-	-	-	-

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 30. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, Дээд боловсролын түвшин, 2021-2024 он

Үзүүлэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин	Суурь түвшин	Зорилтот түвшин
Их, дээд сургуулийн тоо	88	-	88	69	-	88	64	88 (2021)	86	88 (2021)	65
Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	165	-	500	508	-	500	103	165 (2021)	500	-	-
Тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо	1531*	-	3,727**	5,824**	-	3,727**	3,271	5,466 (2021)	4,000	11,063 (2021)	12,393
Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй эзэлд хамрагдсан суралцагчийн тоо		-	15,000	7,168	-	15,000	14,347	11,003 (2021)	15,000	-	-
Дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцах тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо		-	-	-	-	-	400	286 (2021)	400	-	-

\*зөвхөн багш, инженерийн чиглэлийн суралцагч

\*\*зөвхөн багш, сувблагч чиглэлийн суралцагч

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 31. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Насан туршийн боловсрол”, 2021-2024 он

Үзүүлэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин	Суурь түвшин
Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох хүний тоо	6248	5270	-	5068	5108	5313 (2021)	5430	5095	5270 (2021)	5270	5270
Цахим ур чадвар олгох сургалтад хамрагдсан 25-45 насны иргэдийн тоо	-	-	-	-	-	11344 (2021)	15000	15120	9576 (2021)	9576	9576
Мэдээлэл, харилцаа холбооны ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах хүний тоо	5427	9576	-	-	-	-	-	-	-	-	-
Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадвар эзэмшсэн хүн амын хувь	-	-	-	15	12.4	-	-	-	-	-	-
Бичиг үсэг, тоо тооллын хэрэглээний чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хамрагдах хүний тоо	2605	1956	-	-	-	-	-	-	-	-	-

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 32. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Сургалтын биет орчин” хөтөлбөр, 2022, 2024 он

Үзүүлэлт	2022 он			2024 он	
	Суурь түвшин	Зорилгот түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгот түвшин
Сургалтын нэг компьютерийг ашиглах суралцагчдын тоо	-	25	24	24	10
Интернетэд холбогдсон сургалтын зориулалттай компьютерийн хувь	-	60	71	-	-
Нэг ээлжээр хичээллэх боломжтой сургуулийн хувь	-	42	37	-	-
Хүчин чадал ашиглалтын хувь	-	140	141	-	-

Эх сурвалж: БШУЯ, СЯ

Хүснэгт 33. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, “Тусгай хэрэгцээт боловсрол”, 2021–2024 он

Үзүүлэлт	2021 он			2022 он			2023 он			2024 он	
	Зорилгог түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгог түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгог түвшин	Бодит (хүрсэн) түвшин	Суурь түвшин	Зорилгог түвшин	Суурь түвшин
Сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуулийн тусгай сургуульд хамран сургалтын хувь	6251	5606 (хүүхдийн тоогоор)	-	-	-	1.3 (2021)	2	2	0.8 (2021)	-	0.8
Ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	5606 (19.6%)			5673 (18.3%)			6283 (20.9%)			-	
Тусгай хэрэгцээг сургуульд суралцагчдын тоо	1720 (6.0%)			-			-			-	
*Ерөнхий боловсролын сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	28666			31081			30032			-	
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо	712,400 (0.8%)			746,400 (0.8%)			771,700 (0.8%)				

\*Тус тоог нийт хүн амд эзлэх сургуулийн насны хүүхдийн хувиар жиллэн тооцсон

Эх сурвалж: БШУЯ, СЯ



Хүснэгт 35. Хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2022 он

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургуулийн өмнөх боловсрол	564.0	548.2	15.8
2	Ерөнхий боловсрол	1,152.3	1,141.4	10.9
3	Дээд боловсрол	41.0	58.7	(17.7)
4	Мэргэжлийн боловсрол	87.5	80.9	6.6
5	Шинжлэх ухаан, технологи	71.7	59.7	12.0
6	Насан туршийн боловсрол	5.5	5.4	0.1
7	Тусгай хэрэгцээт боловсрол	5.0	4.8	0.2
8	Боловсрол, шинжлэх ухааны боллого, удирдлага	309.0	315.6	(6.7)
9	Боловсрол, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ	9.9	9.1	0.8
	Нийт	2,245.7	2,223.8	21.9

Эх сурвалж: УАГ



Хүснэгт 36. Хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөг, 2023 он

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Гүйцэтгэх засаглалын удирдлага	0.0	0.02	(0.02)
2	Сургуулийн өмнөх боловсрол	767.8	764.1	3.7
3	Ерөнхий боловсрол	1,444.1	1,436.2	7.9
4	Дээд боловсрол	97.1	73.5	23.6
5	Мэргэжлийн боловсрол	160.3	126.4	33.9
6	Шинжлэх ухаан, технологи	88.8	86.2	2.6
7	Насан туршийн боловсрол	8.5	8.3	0.1
8	Тусгай хэрэгцээг боловсрол	6.0	6.0	0.0
9	Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага	554.2	539.5	14.7
10	Боловсрол, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ	9.0	8.6	0.4
11	Жендэрийн тэгш байдлыг хангах	0.03	0.0	0.03
	Нийт	3,135.8	3,048.8	87.0

Эх сурвалж: УАГ

ISBN 991991369-3



9 789919 913694